

ӨРХ, СУМЫН ЭМНЭЛГИЙН  
ЭМЧ, МЭРГЭЖИЛТЭН,  
АРДИРГЭДЭД ЗОРИУЛАВ.

# ОСОЛ ГЭМТЛИЙН ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ

(Цуврал гарын авлага-  
Хоёрдугаар хэвлэл)



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ЯАМНЫ ХАРЪЯА ГЭМТЭЛ СОГОГ  
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

**ОСОЛ ГЭМТЛИЙН ҮЕД  
ҮЗҮҮЛЭХ АНХНЫ  
ТУСЛАМЖ**

Улаанбаатар хот

2007 он

## Өмнөх үг

Монгол улсад Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр 2002 онд Засгийн гаврын 156 дугаар тогтоолоор батлагдаж 2003-2008 онуудад бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх иж бүрдэл арга хэмжээний чухал зүйлийн нэг нь гэмтэж бэртсэн хүмүүст анхны тусламжийг цаг алдалгүй, зөв үзүүлэх явдал юм.

Гэнэтийн осол гэмтэл, хавсарсан гэмтлийн үед эмнэлгийн мэргэжлийн багийг сургаж дадлагажуулах нь чухал юм. Гэнэтийн осол гэмтэлд өртөгсөдөд хамгийн эхэнд анхан шатны тусламж үзүүлдэг өрх, сумын эмнэлгийн эмч мэргэжилтэн, нийт ард иргэдэд энэхүү гарын авлагыг зориулав.

Та бүхний мэдлэгт дэм болбол бидний зорилго биелэх болно.

ГССҮТ-ийн захирал, Осол гэмтлээс сэргийлэх төслийн удирдагч, клиникийн профессор

С.Отгонгэрэл

Боловсруулсан; Ш.Нансалмаа, ГССҮТ -ийн НЭМ-ийн эмч

П.Эрдэнэсан, ЭМШУИС-ийн багш Б.Батзориг,

ГССҮТ-ийн клиникийн эрхлэгч С.Сүхбат,

ГССҮТ -ийн их эмч Ц Цагаандарь, ГССҮТ-ийн

ЭМД-ийн эмч

Хянасан: Р.Шагдарсүрэн, Анагаахын ШУ-ны доктор,

дэд профессор

Д.Мөнхбат, Клиникийн

профессор, ГССҮТ -ийн дэд захирал

Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв

Сургалт Судалгааны Алба

Баянгол дүүрэг 7 -р хороо

Шуудангийн хайрцаг 23/316

Утас: 70180143

## ГАРЧИГ

1. Анхны тусламжын тухай	5
2. Яаралтай анхны тусламж	11
3. Цус алдалт	22
4. Шарх	26
5. Зөөлөн эдийн битүү гэмтэл	34
6. Тархи нугасын гэмтэл	39
7. Үений мултрал	46
8. Ясны хугарал	58
9. Түлэгдэлт	62
10. Нам температурын нөлөөгөөр үүсэх эмгэг	66
11. Хордлого	71
12. Нүдний гэмтлүүд	75
13. Шок	79
14. Зөөвөрлөлт	82
15. Анхны тусламж үзүүлэх үед ариун цэврийг сахих нь	87
16. Анхны тусламжийн иж бүрдэл	93
17. Иргэний эрүүл мэндийн Даатгалын тухай хуулиас	95

## НЭГ. АНХНЫ ТУСЛАМЖИЙН ТУХАЙ

Хүмүүс аливаа аюул ослоос өөрийгөө хамгаалж байдаг боловч осол гэмтэл тохиолдохгүй гэх баталгаа байдаггүй. Иймд гэнэтийн осол тохиолдсон үед нэрвэгдэгсдэд анхны зөв тусламжийг оновчтой, хүрэлцэхүйц, тодорхой дэс дараалалтайгаар үзүүлж сурах нь иргэн бүрийн үүрэг юм.

Анхны тусламж гэдэг нь бүх төрлийн осол гэмтэл, гэнэтийн биеийн хямрал, өвчин эмгэгийн үед эмнэлгийн тусламж иртэл гарын доорх материалыг ашиглан нэрвэгдэгсдэд үзүүлэх тусламжийг хэлдэг.

Анхны тусламжийг зөв үзүүлснээр:

- Амь нас аварна.
- Осол гэмтлээс шалтгаалсан хүндрэлүүдээс сэргийлнэ.
- Эдгэрэлтийг түргэсгэнэ.
- Эмчилгээний зардлыг бууруулна.
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг богиносгох, идэвхтэй амьдралыг эрт сэргээх ач холбогдолтой юм.

Ялангуяа хүнд осол гэмтлийн үед анхан шатны тусламж үзүүлэх дараалал ёсоор анхан шатны үзлэгийг сэхээн амьдруулах үйл ажиллагаатай зэрэг эхлэх, анхан шатны үзлэгийг төгс, түгээмэл үйлдлийн дагуу хийж дуусгаад, 2 дахь шатны үзлэг хийх, 2 дахь шатны үзлэг дуусгаж эмчилгээг эхлэх нь зохилтой. Өвчтөнийг гэмтлийн зэргээр нь ялгалт хийж, уг гэмтэлд нь тохируулж эмчилгээ хийхийг триаж гэж нэрлэх ба энэ нэрийг нь дор дурьдсан зүйлүүдийг бэлэн болгоно. Үүнд:

- Эмнэлгийн тусламжийн үйлчилгээний хэрэгцээ хүрэлцээтэй эсэх
- Мэргэжлийн эмч эсвэл тусламж үзүүлэгч нь бэлтгэгдэн байх
- Бэлэн байгаа нөөц бололцоо

Анхны тусламжийг дараах үндсэн зарчмыг баримтлан үзүүлнэ.



Эдгээр зарчмуудыг баримтлан дарааллын дагуу ажиллах хэрэгтэй.  
Одоо дээрх дөрвөн зарчмаа дэлгэрүүлэн тайлбарлая.

Нэг. Ослын газрыг судлах

- Чухам ямар осол болоо вэ?
- Тохиолдсон осол хэр зэрэг аюултай вэ?
- Хичнээн хүн осолд өртөөд байна вэ?
- Ослын газрын эргэн тойронд байгаа хүмүүсээс Танд туслах хүн байна уу? Гэдэг асуултуудад юуны түрүүнд хариулт олох хэрэгтэй.

Ослын газрыг судлахдаа, эргэн тойрноо сайтар ажиглаж таны болон бусад хүмүүсийн амь насанд аюул учруулах ямар нэгэн зүйл байгаа эсэхийг сайтар нягтална. Хэрвээ таны амь насанд аюул учрахаар бол зохих газарт нь мэдэгдэж хүлээх хэрэгтэй. Харин Танд ямар нэгэн аюулгүй тохиолдолд тусламж үзүүлж болно.

Үүний дараагаар эргэн тойрондоо осолд өртсөн өөр хүн байгаа эсэхийг шалгаж, хэрэв нэгээс илүү хүн осолд өртсөн бол ойролцоо байгаа хэн нэгнээс тусламж хүсэх хэрэгтэй. Эргэн тойронд хэн ч байхгүй бол чангаар хашгирах, гэрэл гаргах зэрэг ямар нэгэн тохиромжтой аргаар тусламж дуудах нь зүйтэй. Осолд өртсөн, тусламж үзүүлэх гэж буй хүндээ дөхөж очоод хэсэг хугацаанд ажиглах ба шууд гэмтсэн хүнийг хөдөлгөх, цочоох зэрэг үйлдэл хийхгүй байхыг анхаар. Хэрвээ гэмтсэн хүн тусламж авахаас татгалзвал түр орхиж нэн яаралтай эмнэлгийн тусламж дуудах хэрэгтэй. Хэрвээ ухаангүй бол шаардлагатай арга хэмжээг нэн даруй авах нь зүйтэй.

Хоёр. Эхний үзлэгийг хийх

- Ухаантай байгаа эсэх
- Амьсгалын зам чөлөөтэй эсэх
- Өөрөө амьсгалж чадаж байна уу
- Судасны лугшилт аль судсанд байна
- Цус алдаж байгаа эсэхийг нягтлан шалгана.

Эхний үзлэгийг хийхдээ эхлээд гэмтсэн хүн ухаантай байгаа эсэхийг хамгийн түрүүн

тогтоодог бөгөөд үүнийг асуулт асуух болон татаж үзэх, зөөлөн цохих зэрэг ямар нэгэн аргаар мэдэж болно. Ямар ч тохиолдолд хэсэг хугацаанд ажиглах нь зүйтэй.

Гэмтсэн хүний амьсгалын зам чөлөөтэй эсэхийг зайлшгүй шалгах ёстой. Ярьж байгаа хүний амьсгалын зам чөлөөтэй байна гэсэн үг. Харин ухаангүй байгаа хүний булчингууд сулран хэл нь хоолой уруу унжиж агаар орох замыг хаадаг. Иймд амьсгалын замыг чөлөөтэй байлгахын тулд ухаангүй байгаа хүнийг эргүүлэх байрлалд буюу хажуугаар нь хэвтүүлж эрүүг татан амыг нь ангайлгана. Хэрэв амны хөндийд ямар нэгэн зүйл /цэр, бөөлжис, хиймэл шүд гэх мэт/ байвал түүнийг хуруугаараа ухаж гаргах хэрэгтэй. Хэл унасан байвал хэл баригчаар барьж гаргах. Амьсгалыг шалгах - Амьсгалын замыг чөлөөлсний дараа амьсгалж байгаа эсэхийг шалгана. Хэрэв цээж нь төвхөлзөн хөдөлж байвал амьсгалж байна гэж үзнэ. Гэхдээ зөвхөн цээжний энэ хөдөлгөөнөөр амьсгалж байгаа эсэхийг тогтоох аргагүй юм. Иймд сайтар нягтлахын тулд чихээ цээжинд нь наан чагнах, хамрын үзүүрт хөвөн утас, үс барьж үзэх, гараараа цээжин дээр дарж тэмтрэх зэрэг аргуудаар шалгаж болно. Үүнийг нийтдээ 3- 5 секундын хугацаанд хийх хэрэгтэй. Эрүүл, насанд хүрсэн хүн 1 минутанд ойролцоогоор 16-18 удаа амьсгалд аг.

Судасны цохилтыг шалгах - Үүнийг хийхдээ шуу, гүрээ, цавь, тахимны хонхор, шагайн судсууд дээр тэмтэрч болох ба эдгээрээсхамгийн сайн тэмтрэгддэг нь шуу болон гүрээний судсууд юм.

Эрүүл, насанд хүрсэн хүнд судасны цохилт 1 минутанд ойролцоогоор 60-80 удаа тоологддог. Үүнээс ихсэх буюу багасах нь ямар нэгэн эмгэг байгааг харуулна.

Цус алдаж байгаа эсэхийг шалгах - Биеийн аль нэг хэсгээс цус алдаж байгаа эсэх нь ил



харагдах тул шалгахад хялбар. Гэхдээ дотуур цус алдаж байвал түүнийг тодорхойлоход төвөгтэй байдаг. Энэ тухай цус алдалт гэсэн сэдэвт дэлгэрэнгүй толилуулах болно.

Гурав. Эмнэлгийн тусламж дуудах

Анхны тусламжийн үндсэн зарчмуудын -эг гол хэсэг нь аль болох түргэн эмнэлгийн тусламж дуудах явдал юм. Осол болсон газрын тухай болон осолд өртөгчийн биеийн байдлын талаар Таны өгч байгаа мэдээлэл нь үнэн зөв, дэлгэрэнгүй, шуурхай, тодорхой байвал эмнэлгийн ажилтнуудад шаардлагатай арга хэмжээг нэн даруй авах бололцоог олгодог.

Дөрөв. Хоёрдох үзлэгийг дараагийн бүлэгт дэлгэрэнгүй өгүүлнэ.

Хэрэв Та эхний үзлэгээр ноцтой шинж тэмдгүүд илрүүлсэн бол тэр даруй анхны тусламжийг үзүүлэх хэрэгтэй. Хоёрдох үзлэгээр эхний үзлэгээр илрээгүй буюу амь насанд аюул багатай өөр ямар нэгэн гэмтлийг илрүүлж болно.

1. Гэмтсэн хүнд өөр ямар нэгэн зовиур байгаа эсэхийг асуух
2. Амьсгалынхэмнэл, судасны цохилт, арьсны өнгө, биеийн дулааныг шалгах
3. Бүх биеийн үзлэг, толгой, хүзүү, цээж, хэвлийн эцэст тулгуур хөдөлгөөний эрхтэнг үзнэ.

Хоёрдох үзлэгийг дээрх дэс дарааллаар эмнэлгийн тусламж иртэл 5 минут тутам хийж илрүүлсэн мэдээллээ бичиж тэмдэглэх хэрэгтэй.

Осолд орсон өвчтөний анхан шатны болон дахь шатны үзлэгийг бүрэн хийх хэрэгтэй. Ялангуяа дор дурьдсан осолд орсон тохиолдолд. Үүнд өгүүлэмжид:

- 3 км ба түүнээс дээш өндрөөс унасан
- 30 км цагаас дээш хурдтай үед гарсан зам

тээврийн осол

- Машинаас шидэгдсэн болон дугуйнд дайрагдсан
- Автомашин нь явган зорчигч болон дугуйтай хүнийг дайрсан
- Автомашин зохих байрлалаа эзлээгүй явсны улмаас гарсан осол
- Тулалдааны улмаас гарсан осол
- Өндөр болон нам хурдтай зэвсгээр гэмтсэн гэсэн өгүүлэмжтэй өвчтөнүүд

Үзлэгээр:

- Амьсгалын зам, уушги дарагдах
- Цусны даралт 100 ммМУБӨ-өөс бага байх
- Глазго-гийн комын шаталбар бага байгаа үед
- Нэвтэрсэн гэмтлүүд
- Нэгээс олон бүс гэмтэлтэй байдлаар илэрнэ.

Хэрэв өвчтөн ямар нэг ойлгомжгүйгээр

муудаж эхэлбэл та анхан шатны үзлэг шинжилгээг давтах ёстой

## ХОЁР. ЯАРАЛТАЙ АНХНЫ ТУСЛАМЖ

Яаралтай анхны тусламж гэдэг нь ямар нэгэн амь насанд аюул заналхийлсэн, ноцтой осол гэмтлийн үед хүний амийг аврах зорилгоор нэн даруй авч буй арга хэмжээг хэлнэ. Иргэн бүхэн энэхүү арга хэмжээг сайн эзэмшиж, туршлагажих хэрэгтэй юм. Үүнд:

- Яаралтай үзлэг хийж, гэмтлийн байдлыг тогтоож, амь насанд аюултай гэмтэлд анхны зөв тусламж үзүүлж, эмчилгээг хийж эхлэх
- Амьсгалын замыг чөлөөтэй болгож амьсгалуулах ур чадвар, маш энгийн аргаар зохиомлоор амьсгалуулах арга хэмжээ авах, шаардлагатай үед мэргэжлийн эмч цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавих.
- Судасны гуурсыг аль олдож байгаа судсанд найдвартай хийх – эмч
- Шокийн эмчилгээ – эмч
- Нурууны гэмтэлтэй өвчтөнд тусламж үзүүлэх, татлага хийж зөв байрлуулах - тусламж үзүүлэгч эмч
- Цээжний хөндийд гуурс тавих - эмч Эдгээр арга хэмжээг дараах дарааллаар гүйцэтгэх нь зүйтэй.

### DRABЗарчим

D-danger - аюулыг шалгана. Тухайн осол танд болон бусдад, мөн гэмтсэн хүний амь насанд хэр аюултай байна вэ гэдгийг тогтоох зорилготой.

1. Гэмтэл учруулж байгаа аюул үргэлжилж байгаа эсэхийг шалгана.

Жишээлбэл: гал түймэр, угаарын хий, цахилгаан

гүйдэл гэх мэт

2. Хэрвээ боломжтой бол гэмтсэн хүнээ аюулаас холдуулах эсвэл аюулыг зайлуулна. R-response - ухаантай эсэхийг шалгана.

A. Насанд хүрсэн хүн болон ярих чадвартай хүүхэд байвал

1. Нэрийг нь асуух
2. Мөрөн дээрээс нь зөөлөн татах

Б. Хэрэв 1 хүртэлх настай хүүхэд байвал Зөөлөн ярьж, дуудаж сэрээж болно.


АНХААР!

1 хүртэлх насны хүүхдийг мөрөн дээрээс нь татах буюу хөдөлгөж болохгүй.

Гэмтсэн хүний ухаантай байгаа эсэхийг гадаад төрх байдлаар нь мөн дээрх үйлдлээр шалгаж мэднэ.

Хэрвээ Та тэр хүнээ ухаангүй байна гэж таамаглаж байгаа бол эхний үзлэгийг толгойноос хөл хүртэл дэс дарааллаар хийнэ. Үүний тулд:


1. Сэрээх оролдлого хийж зөөлөн татна.



2. Үнэртэнэ / ухаангүй байгаа хүнээс архи, тамхи, зм гэх мэт зүйлс унэртэж байна уу?
3. Дух, шилэн хүзүү орчим ямар нэгэн гэмтэл байна уу? / шарх, цус алдалт, хаван гэх мэт
4. 2 чихнээс нь цус гарч байна уу?
5. 2 гарт гэмтэл байгаа эсэхийг үзээд ямар нэгэн ил шарх байхгүй бол үеэр нугалж, тэнийлгэж үзнэ.
6. Цээж, хэвлийд гэмтэл байгаа эохийг үзнэ.
7. 2 хөлд гэмтэл байгаа эохийг шалгаад ил шарх байхгүй тохиолдолд үеэр нугалж, тэнийлгэж үзнэ.

Ингэхэд гэмтсэн хүн ямар ч хариу өгөхгүй бол яаралтай эргүүлэх байрлалд оруулна

**A-Airway**-амьсгалын замыг шалгаж, чөлөөлнө.



*Амьсгалыг хэрхэн шалгах вэ?*

1. Цээжний төвхөлзөх хөдөлгөөнийг ажиглана.
2. Чихээ цээжинд нь наан чагнана.
3. Хамрын үзүүрт хөвөн утас, үс барьж болно.
4. Нүдний шилийг хамарт нь ойртуулан барьж үзэж болно.
5. Гараа цээжин дээр нь тавьж тэмтрэх гэх мэт аргуудаар амьсгалж байгаа эсэхийг шалгаж болно.

Амьсгалын замыг шалгаж чөлөөлснөөр хүний амьсгалах нөхцөл бүрддэг.

Ухаангүй хүний амьсгалын зам бөглөрөх нь:

- Хэл унжих /бүх биеийн булчингууд суларснаас хэл нь хоолой руу унжиж агаар орох замыг хаадаг/
- Хатуу болон хагас хатуу биетүүд / хоол, бөөлжис, цус, хиймэл шүд гэх мэт/
- Амьсгалын замын гэмтэл, хавдар гэх мэт шалтгаануудаас болдог.

Ярьж байгаа хүний амьсгалын зам чөлөөтэй байна гэсэн үг.

**B-Breathing**-амьсгалын замыг чөлөөлж амьсгалуулах

Гэмтсэн хүний амьсгалыг 10 секунд орчим шалгасны дараа амьсгалын замд байгаа саадыг арилгах арга хэмжээг авна.

**Хэрвээ амьсгалын зам дээрх шалтгаануудын улмаас бөглөрсөн бол амьсгалын замыг хэрхэн чөлөөлөх вэ?**

1. Амыг нь ангайлган аман доторхи зүйлийг хуруугаараа ухаж гаргана.
2. Толгойг хажуугаар нь зөөлөн гэдийлгэнэ.
3. Анхны тусламж үзүүлэгч нь 1 гараа шилэн хүзүүн доогуур оруулж бага зэрэг өндөрлөөд нөгөө гараараа духнаас нь барьж гэдийлгэнэ.
4. Эрүүг доош татаж амыг ангайлгана. Амьсгалын замыг чөлөөлсний дараа амьсгалахгүй хэвээр байвал доор өгүүлсэнчлэн зохиомол амьсгалыг хийнэ.

C-circulation - цусны эргэлтийг шалгах буюу судасны цохилтыг үзэх

1. Том тараагуур судсууд дээр судасны цохилтыг тэмтэрнэ.
2. Арьсны өнгө болон ам, хамрын гурвалжинг харна.

Судасны цохилтыг хэрхэн үзэх вэ?

- Насанд хүрсэн хүн болон 9-өөс дээш насны хүүхдэд: Гүрээний эсвэл шууны судсан дээр долоовор болон дунд хуруугаар зөөлөн тэмтэрнэ.
- 1 хүртэлх насны хүүхдэд: Бугалганы дотор талд долоовор, дунд хурууг байрлуулж зөөлөн тэмтэрнэ.

Судасны цохилтыг эрхий хуруугаар хэзээ ч тэмтэрч үздэггүй. Учир нь эрхий хурууны өөрийнх нь судасны цохилт мэдэгддэг, мөн арьс нь зузаан учир муу мэдэрдэг.

Хэрэв гэмтсэн хүн ухаангүй, амьсгалж байвал түүний амьсгалыг дэмжих зорилгоор эргүүлэх байрлалд оруулна.

### **Эргүүлэх байрлалд хэрхэн оруулах вэ?**

1. Ухаангүй байгаа хүнийхээ хажууд сөхөрч сууна.
2. Эргүүлэх талын хөлийг өвдгөөр нь нугална.
3. Тэр талын гарыг тохойгоор нь нугалж эсрэг талын мөрөн дээр давуулан тавина.
4. Тусламж үзүүлэгч 1 гараараа нугалсан өвдөгнөөс барьж, нөгөө гараа хүзүүн доогуур нь хийж эргүүлнэ.

Эргүүлэх байрлалыг аль ч тал руу эргүүлэн хийж болох ба өөрт болон ухаангүй байгаа хүндээ аль эвтэйхэн тал руу эргүүлнэ.



*Зураг 4. А, Б: эргүүлэх байрлал*

Харин амьсгалахгүй байвал CPR буюу зүрх - уушгины сэхээн амьдруулалтыг хийнэ.

#### **CPR гэдэг нь:**

Cardio - зүрх

Pulmonary - уушиг

**Resuscitation** - сэхээн амьдруулалт гэсэн утгатай бөгөөд дэлхийн аль ч улс орнуудад CPR гэж товчлон нэрлэдэг.

1. Гэмтсэн хүнээ дээш харуулж хэвтүүлнэ.
2. Толгойг гэдийлгэн эрүүг өргөнө.
3. Амьсгалын зам чөлөөтэй эсэхийг шалгаж чөлөөлнө.
4. 1 гарын эрхий, долоовор хуруугаараа хамрын үзүүрийг чимхэн духан дээр байрлуулна. Нөгөө гараараа эрүүнээс татаж эрүүг дээшлүүлэн амыг нь ангайлгана.

5. Зохиомол амьсгал өгнө. Үүнийг 3 янзаар өгч болно.

- а/ амнаас аманд
- б/амнаас хамарт
- в/ амнаас ам, хамарт

6. 1 удаагийн амьсгалыг 1.5 - 2 секунд орчим өгнө.

Амьсгал өгөх буюу үлээх үедээ гэмтсэн хүнийхээ цээж рүү 45 0 налуугаар харна. Хэрэв амьсгалыг зөв өгвөл цээж төвхөлзөн хөдлөх ёстой. Цээжний хөдөлгөөнийг харахын тулд хувцасны энгэрийг задгайлж цээжийг ил гаргасан байх нь зүйтэй.

Үүнийг 2 удаа давтан хийнэ.



*Зураг 5. А, Б: Зохиомол амьсгал*

7. Судасны цохилтыг шалгаж үзнэ /судасны цохилтыг хэрхэн шалгахыг дээр дурдсан/.

***Хэрэв судас цохилохгүй бол: зүрхний иллэгийг хийнэ.***


1. Тусламж үзүүлэгч гэмтсэн хүний цээжин дээр эхлээд нэг гараа байрлуулна.

- Үүний тулд эхлээд өвчүүний дээд, доод өнцгийг олно.
- Энэ 2 цэгээсээ өвчүүний гол руу ижил хэмжээний зайнд орших цэг буюу өвчүүний голыг олно.
- Энэ цэгт нэг гарын алганы ирмэгийг байрлуулна.

2. Нөгөө гараа дээр нь давхарлан байрлуулж атгана.



3. 2 гараа нугалахгүй, босоо чиглэлээр, эгц доош, цээжийг 4-5 см хотолзтол дарна.
4. 1 удаагийн даралтын дараа даралтын хүчийг бууруулж сулруулаад гараа цээжнээс салгахгүй дараагийн даралтыг үргэлжлүүлнэ.
5. Ийм маягаар нийтдээ 15 удаа зүрхэнд даралттай иллэг хийнэ.



Зураг 6. А, Б, В, Г, Д, Е: Зүрхний даралттай иллэг



Зураг 7.

Үүний дараа судасны лугшилтыг дахин заавал үзнэ. Өөрөөр хэлбэл, дээрх үйлдлүүд нь дэс дараатай, үйл ажиллагаа бөгөөд бүхэлд нь CPR буюу зүрх уушгины сэхээн амьдруулалт гэж хэлдэг. CPR-ийг томьёолбол: **зохиомол амьсгал / зүрхний даралт = 2/15** гэсэн харьцаатай

байна. CPR нь ямар насны хүмүүст хийх гэж буйгаас шалтгаалан доорхи ялгаануудтай. Үүнд:

**А. 1-8 настай хүүхдэд:**

1. 1 удаа амьсгал өгнө.
2. Судасны лугшилтыг үзнэ.
3. Өвчүүний голд 1 гарын алгыг байрлуулна.
4. 5 удаа зүрхний даралттай иллэг хийнэ. Өөрөөр хэлбэл: Зохиомол амьсгал / зүрхний даралт = 1/5 гэсэн харьцаатай байна.

**Б. 1 нас хүртэлх хүүхдэд:**

1. 1 удаа амьсгал өгнө. Дараагийн ээлжинд удаа өгнө.
2. Судасны лугшилтыг үзнэ.
3. Өвчүүний голд долоовор, дунд хуруугаараа дарна.
4. Даралтыг 5 удаа хийнэ.

Өөрөөр хэлбэл: Зохиомол амьсгал / зүрхний даралт =  
1/5    2/5

Хэрэв судас цохилж байвал:

1. 4 секундэнд 1 удаа зохиомол амьсгал өгнө.
2. Амьсгал, судасны лугшиптыг минут тутамд шалгана.

**В. 0-1 настай хүүхдэд:**

1. Хүүхдийг дээш нь харуулж хэвтүүлнэ.
2. Тусламж үзүүлэгч гэмтсэн хүүхдийн ам, хамарт нь зэрэг амьсгал өгнө. Зохиомол амьсгалыг 3 секунд тутамд 1 удаа зөөлөн өгнө.
3. Амьсгал, судасны лугшилтыг минут тутамд шалгана.

CPR-буюу зүрх уушгины сэхээн амьдруулалтыг 2 хүн зэрэг хийж болно.

Эхний хүн зохиомол амьсгал өгч судасны цохилтоо үзэх, нөгөө хүн зүрхний даралттай иллэг хийх буюу үүнийг хийж байгаа хүн чанга тоолох хэрэгтэй.

## Дээрх үйлдлийг схемчлэн үзүүлбэл:

	9-өөс дээш насны хүүхэд ба том хүн	1-8 насны хүүхэд	Нярай хүүхэд
Гарын байрлал	2 гараар өвчүүний доод ½-т	1 гараар өвчүүний доод ½-т	2 гараар өвчүүний доод ½-т
Даралттай иллэг	4-5 см	2-3 см	1-2 см
1 хүн хийх	15 секундэд 15 даралт 2 амьсгал	10 секундэд 15 даралт 2 амьсгал	10 секундэд 15 даралт 2 амьсгал
2 хүн хийх	5 даралт 1 амьсгал /60 секундэд 60 даралт 15 амьсгал/	5 даралт 1 амьсгал /60 секундэд 100 даралт 20 амьсгал/	5 даралт 1 үлээлт /60 секундэд 100 даралт 20 амьсгал/

## Хоёр дахь шатны үзлэг

Зөвхөн өвчтөний амьсгал зүрх судас болон цусны эргэлтийн үйл ажиллагааг тогтворжсоны дараа 2 дахь шатны үзлэгийг сум, ерхийн эмч хийнэ.

Энэ үе шатанд ямар нэг дутуу дулимаг зүйл илэрвэл, анхны үзлэг рүү эргэн орох хэрэгтэй болно. Бүхий л тусламж, ажилбарыг баримтжуулах шаардлагатай. Үүнд толгойноос хөлний ул хүртэлх дараах үзлэгүүд хамаарна.

- **Толгойн үзлэг**

- Хуйх болон нүдний хэвийн бус байдал, эмгэг
- Гадна чих ба хэнгэргэн хальс
- Ухархай орчмын зөөлөн эдийн гэмтэл

- **Хүзүүний үзлэг**

- Нэвтэрсэн шарх
- Арьсан дор хий хурах
- Төвөнх хазайсан эсэх
- Хүзүүний вен тодорч харагдах
- Хүзүүний хэлбэр дүрсийг харна

- **Мэдрэлийн үзлэг**

- Тархины үйл ажиллагааг Глазгогийн шаталбар үнэлгээгээр үнэлэх
- Нугасны хөдөлгөөний болон мэдрэхүйн үйл ажиллагаа
- Мэдрэхүй ба рефлекс

- **Цээжний үзлэг**

- Цээжний хэлбэр дүрсийн байдал
- Эгэм ба хавирга

- Амьсгал ба зүрхний авиа
- Боломжтой бол зүрхний цахилгаан бичлэг хийх
- **Хэвлийн үзлэг**
- Хэвлийн хөндийг нээх шаардлагатай хэвлийн хөндийд нэвтэрсэн шарх бий эсэх
- Битүү гэмтэл: Ходоодны хамраар нарийн зонд оруулна. Нүүрний гэмтэлтэй үед хэрэглэхгүй
- Шулуун гэдсээр үзэх
- Давсганд катетр тавих, катетр тавихын өмнө шээсний сүвээр цус гарсан эсэхийг шалгах
- **Аарцгийн болон дээд, доод мөчдийн үзлэг**
- Хэлбэр дүрсийг ажиглана.
- Ясны хугарал, үений мултрал байгаа эсэх
- Захын судасны лугшилт
- Зүсэгдэн, няцарсан, хуулагдсан, цавчигдсан болон бусад жижиг шархнууд

### **Гэмтлийн онцлог тохиолдлууд**

#### **Хүүхдийн гэмтэл:**

Хүнд гэмтлийн үед түргэн тусламжийн машинд эрт сэхээн амьдруулах эмчилгээ хийгдэх нь хүүхдийг амийг аврах найдвар юм. Гэмтсэн хүүхдийн анхан шатны үзлэгийн үнэлгээ нь насанд хүрэгчдийнхтэй адил юм.

- Амьсгалын зам чөлөөтэй эсэх
- Амьсгал хянах
- Цусны эргэлтийн байдал
- Мэдрэлийн байдлын эрт үеийн үнэлгээ
- Хүүхэд биеийн дулаанаа алдаагүйг магадлах

Цусны эзлэхүүн буурсан хүүхдийн судсыг олох хэцүү. Иймээс тарилгын гуурсийг дотор шагайн хураагуур судас, гүрээний гадна болон гуяны хураагуур судсанд тус тус тавьж хэрэглэнэ. Хүүхэд нийт цусны 25% хүртэлх хэмжээг алдсан байхад ч хүүхдэд өөрийн физиологийн нөөц хүчин чадал сайтай учир амьдралын чухал эрхтнүүдийн үйл ажиллагааны үзүүлэлт үл ялиг өөрчлөгддөг.

Зүрхний цохилт олшрох нь цусны эзлэхүүн буурсны эрт үеийн хариу урвал боловч хүүхдэд айнаас, өвдөлтөөс болж илэрдгийг анхаар. Хүүхдийн судасны цохилтыг цавинд гуяны артерид, тохойн дээхнэ хонхорт тэмтрэх нь хамгийн тохиромжтой. Мөн хүүхэд дулаанаа амархан алддаг. Учир нь биеийн жинг бодвол гадаргуу их байдаг, ялангуяа толгойгоор дулаанаа илүүтэй алддаг. Хүүхдэд бүх биеийн үзлэг хийсэн ч түргэн хучиж дулаална.

**Жирэмсэн эмэгтэйн гэмтэл:**

Жирэмсэн эмэгтэйд үзүүлэх гэмтлийн тусламжийг ABCDE дарааллын дагуу жирэмсэн биш эмэгтэйн адил үзүүлнэ. Мөн хэвийн үед зүрхний цохилт олширсон, зүрхний ачаалал 30% нэмэгдсэн байдаг. Цусны даралт ердийнхөөс 15 ммМУБӨөөс буурсан байдаг. Эхийг сэхээн амьдруулснаар хүүхдийг нь аварч чадна.

Цус алдалт гэдэг нь арьс салст, эд эрхтэний бүрэн бүтэн байдал алдагдсанаас судасны хана гэмтэж судаснаас цус гарахыг хэлнэ. Цус алдалтыг хэлбэрээр нь:

- гадуур
- дотуур гэж ангилдаг.

Гадуур цус алдалт гэдэг нь гадны янз бүрийн хүчин зүйлийн улмаас арьс, салст, тэнд орших цусны судсууд гэмтсэнээс нүдэнд ил харагдаж байгаа цус алдалтыг хэлнэ.

Дотуур цус алдалт гэдэг нь хүчтэй доргилт, битүү гэмтлийн улмаас эд эрхтнүүд гэмтэх эсвэл дотор эрхтний зарим өвчний хүндрэлээс болж тэнд орших судас гэмтсэнээс биеийн дотуур хөндийд алдаж байгаа нүдэнд үл харагдах цус алдалтыг хэлнэ.

Цус алдалтын үед илрэх ерөнхий шинж тэмдэг нь аль ч хэлбэрийн цус алдалтын үед

- арьсны өнгө цайх
- судасны цохилт олшрох
- толгой эргэх
- бөөлжис цутгах
- нүд бүрэлзэх
- чих шуугих зэрэг ерөнхий шинжүүд илэрнэ.

Гадуур цус алдалтын үед дээрх ерөнхий шинж тэмдгээс гадна цус алдаж байгаа нь нүдэнд ил харагддаг тул танихад маш хялбар.

Дотуур цус алдахад дээрх ерөнхий шинжүүдээс гадна ямар эрхтний хөндийд цус алдаж байгаагаас шалтгаалж харилцан адилгүй шинж тэмдэг илэрдэг. Жишээ нь: тархины судас гэмтэж гавлын хөндийд цус хурвал толгой өвдөх, сэтгэхүйн үйл ажиллагаа алдагдах, хөдөлгөөний болон саатлын байдалд орох, ухаан алдах, саажлын гэх мэт шинжүүд, цээжний хөндийд цус хурвал амьсгаадах, амьсгал давчдах, царай

хөхрөх, цээжээр өвдөх, үений хөндийд цус хурвал үений хөдөлгөөн хязгаарлагдах, өвдөх, хөхрөх, шингэн бамбалзах зэрэг шинжүүд илэрнэ.

### **АНХНЫ ТУСЛАМЖ:**

Хэрвээ бага зэргийн цус алдалттай байвал тусламж үзүүлэхдээ:

- Гараа угаана.
- шархан дээрээ цэвэр бинт эсвэл даавуу тавина.
- Гэмтсэн судасны ханыг шахаж хатуу биетийг тавина.
- боолт хийнэ.
- Мөчийг өргүүлэн сойлт хийнэ. Энэ нь цусны урсгалыг удаашруулах зорилготой.

Энэ хэлбэрийн боолтыг даралттай боолт гэж хэлдэг.



*Зураг 8. А. Б. В. Г: Даралттай боолт*

Хэрвээ цус ихээр алдаж байгаа үед маш яаралтай цус тогтоох дараах аргуудыг нэмж хэрэглэнэ  
Үүнд:

#### **1. Том судасны цэгүүд дээр дарах.**

Цус алдаж байгаа газрын дээд талд байрлах судасны /эгэмний доорх, гуяны, гүрээний, бугалганы, шууны/ цэгүүд дээр ясанд тултал дарна. Ингэхэд цус алдалт багасдаг.

## **2. Даралттай чангалуур боолт**

Үүнийг хийхдээ эхлээд цус алдаж буй газар ариун жийргэвч тавьж, дээр нь гэмтсэн судсанд даралт үзүүлэх төө хэрийн хатуу биетийг тавьж цусыг тогттол чангалан эрчилж бооно. Энэ үед тавьсан даралттай чангалуур боолтыг эмнэлэг хүртэл 10-15 минут тутамд суллаж цус алдалтыг хянаж байх ёстой. Үүний тулд эхлээд тавьсан цаг минутыг заавал бичиж тэмдэглэн гэмтсэн хүний хувцсанд хавчуулах буюу дагалдан яваа хэн нэгэнд заавал анхааруулах ёстой. Эс тэгвэл чангалуур тавьсан хэсгээс захын эрхтэнд үхжил үүсэх аюул заналхийлж байдаг.



*Зураг 9. А. Б: Даралттай чангалуур боолт*  
**АНХААР**

Тавьсан чангалуурыг 10-15 минут тутамд суллахаа бүү март.

Чангалуур боолт тавьсан цаг минутыг заавал бичиж тэмдэглэ.

## **3. Хэрвээ эрхтэн таслагдсан тохиолдолд чангалуур тавьж, боолт хийнэ.**

Таслагдсан мөчнөөс цус алдахад даралттай чангалуур боолтыг тайрагдсан үзүүрээс 1-2 см-т хийнэ. Энэ үед тавьсан боолтыг эмнэлэг хүртэл суллаж хэрхэвч болохгүй. Зөв тавибал захын судасны лугшилт алга болж цус тогтоно. Таслагдсан эрхтнийг мөстэй усанд хийж гэмтсэн хүний хамт эмнэлэгт хүргэнэ.






*Зураг 10. Тасарсан эрхтэнийг эмнэлэгрүү зөөх*

## ДӨРӨВ. ШАРХ

Янз бүрийн шалтгааны улмаас арьс салст, булчин гэх мэт зөөлөн эдүүд гэмтэж бүтэн байдлаа алдахыг шарх гэж хэлдэг.

### Шархны шинж тэмдэг:

- арьс салстын бүтэн байдал алдагдсан байна.
- цус шүүрэх буюу цус гоожино.
- Шархны орчим ямар нэг хэмжээгээр хавдаж, өвдөнө.
- Шархадсан эрхтний үйл ажиллагаа алдагдана.



Зураг 11. А. Б. В. Г: Шархны хэлбэрүүд

Шархыг дараах байдлаар ангилан үздэг.

### А. Шалтгаанаар нь:

- зүсэгдсэн
- урагдсан
- хатгагдсан
- хазагдсан
- огтлогдсон
- буудагдсан гэх мэт

## **Б. Үүссэн байдлаар нь:**

- өнгөц-зөвхөн арьс, салст бүрхэвчийг хамарсан
- гүн -булчин, шөрмөс, яс хүртэл гэмтсэн
- нэвтэрсэн- биеийн аль нэг хөндий рүү нэвтэрч орсон



*Зураг 12. А. Б: Шархны хэлбэрүүд*

## **АНХНЫ ТУСЛАМЖ**

- Эхпээд гараа заавал угаа.
- Өөрийгөө цусаар дамжих халдвараас сэргийлж резин бээлий өмс. Хэрэв бээлий байхгүй бол түүнийг орлуулж гялгар уут ч өмсч болно.
- Шархтай хүнээ тайвшруулж тусалж чадна гэдгээ ойлгуул.
- Шархны эргэн тойрны талбайг цэвэр усаар угаа. Халдваргүйжүүлэх уусмал байвал арчиж болно. Шаардлагатай тохиолдолд спирт хэрэглэж болно.
- Шархан дээрээ ариун бинт эсвэл даавуун жийргэвч тавина.
- Боолт хийнэ.

## **АНХААР!**

1. Том шарх үүссэн бол 6 цагийн дотор эмчид ханд.
2. Шархан дээр элдэв тос, антибиотик зэрэг эм түрхэж болохгүй.
3. Шарханд гадны биет зоогдсон бол авах оролдлого бүү хий.
4. Амьтанд хазуулсан шархыг амаараа бүү сор.

## БООЛТЫН ТУХАЙ


Боолт гэдэг нь шархыг боох буюу мөчдийг хөдөлгөөнгүй бэхлэх зорилгоор бэлтгэсэн материалыг хэлнэ. Аль ч хэлбэрийн шархны үед бид төрөл бүрийн боолтууд хийдэг.

Боолтыг зөв хийж сурснаар:

- шархыг халдвараас хамгаалах
- шархнаас бусдад халдвар тараахаас сэргийлэх
- шархны эдгэрэлтийг түргэсгэх зэрэг ач холбогдолтой юм.


Боолтын төрлүүд:

1. Бинтэн боолт. Энэ нь янз бүрийн өргөн, урттай, хуйлж ороосон даавуун ба сунадаг боолтууд байдаг.
2. Гурвалжин алчуурын боолт
3. Цуулбар боолт



**Боолтын зарим хэлбэрүүд:**

- Бинтээр хийх боолтууд
  - Хэрвээ биеийн аль нэгэн хэсэгт гадны биет орсон тохиолдолд тухайн гадны биетийг авах оролдлого хийлгүйгээр ариун жийргэвч буюу даавуу, самбай тавьж гадуур нь боолт хийнэ. Учир нь шарханд халдвар орох, цус алдахаас сэргийлж байгаа юм.



Зураг 13. А. Б. В. Г: Гадны биетийг бэхэлж боох нь

- 8-ын тоо хэлбэрийн боолт: энэ боолтыг мөчдийн үенүүд дээр хийдэг. Өвдөг, тохой, сарвуу, шагайны үенүүд дээр боолт хийхэд тогтоц муутай байдаг тул энэ хэлбэрийн боолтыг хийх тохиромжтой байдаг. Үүнийг хийхийн тулд эхлээд үеийг 2-3 удаа ороож дараа нь үений хонхроос дээш ташуу чиглэлтэй үений дээгүүр тойруулаад доош ташуу чиглэлтэй явуулж үений доогуур тойруулаад үйлдлийг давтана.



Зураг 14. А. Б. В. Г: 8-ын тоо хэлбэрийн боолт

- Ороомог хэлбэрийн боолт: Энэ боолтыг мөчдийн шулуун хэсэг дээр байгаа шархыг бооход хэрэглэнэ. Үүний тулд бинтийн эхний үзүүрийг боох мөчний захын хэсэгт 2-3 ороож бэхлээд өгсөх хэсэг үрүү чиглүүлэн ороох маягаар бооно. Ороож боохдоо эхний ороосон боолтын 2/3-ийг дарж байхаар дараачийн ороолтыг хийнэ.



*Зураг 15. А. Б. В. Г: Мөчдийн ороомог боолт*



*Зураг 16. Толгойн ороомог боолт*

- **Гурвалжин алчуураар хийх боолтын хэлбэрүүд**
  - толгойн боолт: алчуурын суурийг духанд байрлуулан, оройг шилэн хүзүүнд авчирч толгойг бүтээн, 2 үзүүрийг нь шилэн хүзүүний орчимд алчуурын оройг дарж зөрүүлэн ороогоод дахин 2 үзүүрээ духны орчим авчран зангидна.



*Зураг 17. А. Б: Толгойн боолт*

- Гарын боолт: алчуурын суурийг бугуй үе үрүү, оройг хурууны үзүүр үрүү их биег боох гарын алган талд байрлуулна. Алчуурын оройг гарын ар гадаргуун дээр давуулан 2 үзүүрээ оройг оролцуулан зангидна. /хөлийн тавхайг үүнтэй ижил бооно/



*Зураг 18. А. Б: Гарын боолт*



*Зураг 19. А. Б: Гарын боолт*



*Зураг 20. Хацрын боолт*

- чих буюу хацрын боолт: гурвалжин алчуураа уртаар нь нугалаад, гэмтсэн талын хацар буюу чихэн дээр биеийн тэнхлэгийн дагуу байрлуулж 2 үзүүрийг эсрэг талын шанаан дээр авчирч зөрүүлээд дахин нөгөө талд аваачин зангидна.



*Зураг 21. Гарын сойлт*

- Гарын сойлт: гарыг тохойн үеэр нугалаад алчуурын суурийг эрүүл талын мөчийн дагуу байрлуулна. Алчуурын голд гарыг тавьж 2 үзүүрийг мөрөн дээгүүр давуулан шилэн хүзүүнд авчран зангидна. Алчуурын оройг тохой орчим зангидна.

- **Цуулбар боолт:**

Цуулбар боолтыг хамар, эрүү зэрэг өнцөгтэй эрхтнүүдийг бооход хэрэглэнэ. Энэ боолтыг бид өөрсдөө бэлтгээд боох боломжтой. Боох даавууны 2 үзүүрийг боох эрхтний хэмжээнд тохирсон талбай үлдээн цуулна. Цуулбар хоорондын хэсгийг боох хэсэгт хөндлөн байрлуулаад үзүүрүүдийг дээш доош нь зөрүүлэн зангидна.







*Зураг 22. Цуулбар боолт*

Бид хамгийн ойр зуур өргөн хэрэглэгдэх цөөн төрлийн боолтуудын тухай өгүүллээ.

Та эдгээр боолтуудыг заавал хийж үзээрэй. Төрөл бүрийн боолтуудыг зөв хийж сурах нь хэзээ нэгэн цагт заавал ач тусаа өгнө гэдгийг бүү мартаарай.

**Шарх бохирдох, халдварлах:**

Шарх нь үүсэх үеэсээ эхлэн бохирдоно. Бохирдолтыг анхдагч, хоёрдогч гэж ангилна. Энэ нь 6-8 цагийн хугацаатай. Энэ хугацаанд орсон микроб орчиндоо дасаж зохицож хуваагдаж үржих үе юм. Няnguудыг үржихэд үхжсэн эд, гаднын биет, цус хурах, хэсэг газрын цусны эргэлтийн хямрал, шок, цус алдалт, тураалтай зэрэг хүний биеийн эсэргүүцэл сулрах нь таатай нөхцөл болдог. Ийнхүү нянгаар анхдагч бохирдсон шархыг халдвар авсан шархнаас ялгаж ойлгох ёстой.

## **ТАВ. ЗӨӨЛӨН ЭДИЙН БИТҮҮ ГЭМТЭЛ**

Гэмтлийн улмаас зөөлөн эдийн гэмтэл нь хугарал, мултралтай хавсарч тохиолдохоос гадна дангаар гэмтэнэ. Зөөлөн эдийн битүү гэмтлийг няцрах, сунах, хагарах, доргих, дарагдах гэж хуваадаг.

**Нэг. Няцралт:** Эд эрхтэн няцрахад судсууд гэмтэж тодорхой хэмжээний цус харвалт үүх, цус хуралт илэрнэ. Эмнэл зүйн хувьд няцарсан эд эрхтэнд үйл ажиллагааны хямрал, хавагналт, цус хуралт, өвдөлт илэрнэ. Том мэдрэлийн судал няцрахад тэр хэсэгт мэдээгүйжих, шокийн шинж илэрнэ. Үений орчим бол идэвхтэй үйл ажиллагаа алдагдаж, цус хуралт үүснэ. Няцралтын үед эхний 1-3 хоногт гэмтсэн мөчинд боолт хийх, хүйтэн жин тавих, цусны эргэлтийг сайжруулах, хаван буулгах зорилгоор мөчдийг биеийн түвшингөөс өндөр сойх байдалд байлгах. Мөчдөд чиг тавина, хатгалт хийгээд цус хуралт багасахгүй, шимэгдэхгүй бол зүслэг хийж авна. 2-3 өдрийн дараа өвдөлт хавагналт намжиж эхлэнгүүт хэсэг газрын дулааны эмчилгээ хэрэглэх бөгөөд мөн иллэг, үенд идэвхгүйгээс идэвхтэй хөдөлгөөнийг хийж эхэлнэ. Хэрэв өвдөгний үе няцарч гэмтсэн бол үенд цус хурж тойг долгилох шинж тэмдэг илэрнэ.

**Хоёр. Зөөлөн эдийн суналт:**

Энэ үед эдийн нэг хэсэг нь тасарч, нөгөө хэсэг нь бүрэн үлдэхийг хэлнэ. Суналт нь ихэвчлэн үенүүдийн холбоосонд ихэвчлэн тохиолдоно. Янз бүрийн гэнэтийн хүчтэй хөдөлгөөн хийх, татагдах механизмаар үүсгэгдэнэ. Хавагнах, цус харвах, хурах, үений үйл ажиллагаа хямрах, өвдөх шинж тэмдгүүд илэрнэ. Үенд бол цус хуралт үүснэ. Оношийгтодруулахад рентген зураг авах нь их ач

холбогдолтой. Үений мултралаас ялгахдаа үенд зөвхөн нэг чиглэлийн хөдөлгөөнд эмзэглэлтэй Суналтын үед эхний өдрүүдэд хүйтэн

жин тавина. 2 долоо хоног гөлтгөнөн аравч чиг тавьж хөдөлгөөнийг хязгаарлана. Дараа нь дулааны эмчилгээ, иллэг хийнэ. Хэрэв өвдөгний үений хажуугийн холбоос сунасан үед уг үенд цус хурахын зэрэгцээ дотор холбоос сунасан үед шилбээр эргүүлэх хөдөлгөөн, шаант чөмөгний дотор ирмэгт дарахад эмзэглэлтэй, гадна холбоос гэмтэхэд өвдөгний мөгөөрсөн жийргэвч тасрах гэмтэл хам тохиолдож болно. Аль ч холбоос сунаж гэмтсэн хурц үед нь 3-4 долоо хоног гөлтгөнөн аравч тавиад дулааны эмчилгээ хийхийн зэрэгцээ онош тодруулах үзлэг, рентген зураг авах шинжилгээг давтан хийх нь зүйтэй.

#### **Гурав. Зөөлөн эд тасарч гэмтэх:**

Өндрөөс унах юманд хүчтэй цохигдох, хавчуулах, хэт хүч гаргах, агшсан булчин шөрмөс хатуу зүйлээр цохигдох үед үүснэ. Үений холбоос тасрах: Үеэр хэт нугалах, тэнийлгэх, хажуугийн мушгих хөдөлгөөн хийх гэх мэт механизмаар үүсгэгдэнэ. Холбоос тасрахад: үеэр эмгэг илүү хөдөлгөөн үүснэ, үенд, зөөлөн эдэд хурна. Эдгээр тохиолдолд хүйтэн жин, үенд хөдөлгөөн хязгаарлах гөлтгөнөн аравч тавина. Булчингийн шар хальс тасрахад завсар тэмтрэгдэхээс гадна булчингийн ивэрхий гарна.

Үенд цус хурсан бол соруулж аваад антибиотик хийнэ. Гөлтгөнөн аравчийг тавихдаа тасарсан холбоосыг ойртуулах байрлалд тавина. 3-4 хоногийн дараа дулааны эмчилгээ үеэр аажим болгоомжтойгоор идэвхгүйгээс идэвхтэй хөдөлгөөн хийлгэж эхлэнэ. Эдгээр эвийн эмчилгээ үр дүнгүй бол нарийн мэргэжлийн эмчид явуулна.

**Дөрөв.** Биеийн аль ч хэсгийн булчин тасарч болно. Булчин хүчтэй агших, хэт татагдсанаас, хүнд ачааг гэнэт хүчтэй өргөхөд Дельта хэлбэрийн болон хоёр толгойт булчин, хүчтэй тэнийлгэхэд 3 толгойт булчин тасардаг, араараа хүчтэй унах үед хэвлийн шулуун булчин, доод мөчдөөс 4 толгойт, эрээн, гуя хавийн булчингууд тасрах нь элбэг тохиолдоно. Булчинг бүрэн болон хагас тасарсан гэж ангилна. Тасарсан түвшингээр нь булчингийн хэсгээрээ, булчин шөрмөсний заагаар, эсвэл шөрмөсөн хэсгээрээ гэж ангилна. Шинж тэмдэг нь булчин тасрахад дуу гарч тэр хэсэгт нь хүчтэй өвдөнө. Сээр талын мөчний хүч суларна, үйл ажиллагаа бүрэн биш болно, булчингийн чангарал алдагдаж, тасарсан хэсгээр нь хонхойн ховилтоно.

Булчин агшихад тэсархайтаж зангирна. Гэмтсэн хэсгээр цус хурж хавагнадаг. Булчингийн тасрал нь мэдрэлийн судал тасрах, үений мултралтай хам байдлаар тохиолдоно. Энэ үед уг мөчдийн болон бүсчилсэн маягаар мэдэрхүй алдагдана. Шөрмөсний тасрал ялангуяа ясанд бэхлэгдсэн хэсгээрээ бол ясны хэсэг хамт ховхордгийг анхаарвал зохино. Бүрэн бус тасарсан бол эхний 1 -3 хоногт хүйтэн жин, мөчдийг тайван байрлалд гөлтгөнөн аравч чигийг 3-4 долоо хоног тавьж өгнө. Гөлтгөнөн аравчийг аваад болгоомжтой аажмаар үеэр идэвхгүй хөдөлгөөн хийх, иллэг, дулааны эмчилгээ хийнэ. Булчин аль ч түвшиндээ бүрэн тасарсан бол даруйхан сэргээх, нөхөн сэргээх мэс заслын эмчилгээ хийнэ.

**Тав.** Арьс хуурч хөндийрөх нь хатуу зүйлд хүчтэй цохигдох, дарагдах, хурц үзүүртэй зүйл дүүжлэгдэх, хавчуулагдах, төрөл бүрийн эргэх механизмуудад гэмтэх, шуу, бугуйн үе, шагайн үеэр мултрахад бас тохиолдож болно. Арьс тэжээх судас бүхий шарх хальс өөхөн эслэгтэйгээ хамт хуурч хөндийрсөн бол буцааж

Байранд нь тавьж бэхэлнэ. /антисептик уусмал антибиотик, новокаины уусмалаар бохирдлыг угааж цэвэрлэнэ/.

Хөндийрсөн арьсанд зүслэг хийхэд шархнаас цус шүүрэхгүй бол арьс цусан хангамжгүй болсны шинж. Хөндийрч үхэжсэн арьсыг цусан хангамж сайтай хэсгээр нь зүсч аваад савантай бүлээн ус, спиртээр ариутгаад 0.9%-ийн натрихлоридын уусмалаар угааж өөх халимыг сайтар авч антибиотик уусмалд хийгээд нөхөх талбайгаа хэд дахин антисептикийн уусмалаар угааж цэвэрлээд арьсаа тавьж оёно. Арьс хуурч гэмтсэн хүнд хүйтэн жин тавьж гөлтгөнөн болон зсвэп гарын доорхи материалыг ашиглаж хөдөлгөөнгүй чиг тавьж өвдөлт намдаах болон бусад шаардлагатай эм тариаг хэрэглэн гэмтэл, мэс заслын эмнэлэгт хүргэх нь зүйтэй.

**Зургаа.** Зөөлөн эдийн дарагдалт гэдэг нь механик үйлчлэлээр зөөлөн эд шахагдаж дарагдсаны улмаас үүссэн эдийн задралын эцсийн бүтээгдэхүүн бие махбодийг гүнзгий хордлогонд оруулж амь насанд аюул учруулдаг онцгой өвөрмөц хүнд гэмтэл юм. Байгалийн гамшиг, газар хөдлөх, барилга, уул уурхай, зам тээврийн осол, үйлдвэрийн, ахуйн зэрэг золгүй тохиолдол, нурангид дарагдахад тохиолдоно. Мөн өндрөөс унах, мод чулуунд цохигдох, морь. малаас ойчиход тохиолдож болно.

Зөөлөн эдийн дарагдалтын эмгэгшил, даамжрах явц нь маш нарийн. Энэ асуудлыг өнөө хүртэл бүрэн тайлбарлаагүй байна.

Дээрхи ангиллуудаас харахад өвчний явц нь дарагдал үүссэн хэсгийн талбай, байрлалаас гадна дарагдсан хугацаа мөн дарж буй зүйлийн жин онцгой нөлөөлдөг байна. Биеийн дарагдсан хэсгийг чөлөөлсний дараа 3-4 цагаас эхлэн хэсэг газрын хаван мэдэгдэхүйц болж эхний 2 өдөр хавагналт нэмэгдсээр байна. Арьс баргар хөх өнгөтэй хүйтэн болно. Цусархаг болон шаргал

өнгөтэй цэврүү үүснэ. Өвчтөнөөс гэмтэл яаж үүссэнийг сайн тодруулах хэрэгтэй. Мөн захын том судасны лугшилт суларч огт мэдэгдэхгүй болж шархнаас цус гоожимтгой байна.

Гэмтэгсдийг дарагдлаас гаргаж авсан даруйд биеийн ерөнхий байдалд онцгой өөрчлөлт гардаггүй боловч бага цочромтгой байснаас гэнэт нойрмог болох, бөөлжүүлэх, царай нь цайж хүйтэн хөлс дааварлаж судасны лугшилт олширч 1 минутын 120-140 хүрч, цусны дарал 80/35 70/20 хүртэл буурч, эдгээр шинжтэмдэгүүд нь шокийн эсрэг эмчилгээнд засарна.

### **АНХНЫ ТҮСЛАМЖ ЭМЧИЛГЭЭ:**

Мөчийг дарагдлаас гармагц өвчин намдаах бэлдмэлүүдийг хэрэглэж чиг тавьснаар эмнэлэгт заавал хэвтүүлнэ. Дарагдлаас дээгүүр чангалуур тавьж хүйтэн жинг хэрэглэх шаардлагатай.

## **ЗУРГАА. ГАВАЛ ТАРХИ, НУРУУ НУГАСНЫ ГЭМТЭЛ**

Гавал тархины гэмтэл нь хүнд гэмтлийн нэг юм.

Бүх гэмтэгсдийн 23-25%-ийг эзэлнэ. Тархины гэмтлийн жамын талаар гарлыг механик, шингэний, цусан хангамжийн, рефлекторийн гэх мэтээр олон онол таамаглал гарчээ.

Гавал тархины гэмтлийн ангилал:

### **I. Битүү гэмтэл**

А. тархины доргилт - *Commotio cerebri*

Б. тархины няцралт - *Contusio cerebri* - хөнгөн зэрэг хүндэвтэр, хүнд зэрэг

В. тархи дарагдах - *Compessio cerebri* Ер нь битүү гэмтлийн үед тархи, зөөлөн эд гэмтэж, гавал яс гэмтээгүй байдаг. Энэ нь халдвар орох аюул багатай боловч гавал тархины дотоод даралт ихэсвэл аюултай.

### **II. Ил гэмтэл**

Хуйх гавал тархи ил гэмтэх:

- тархины хатуу хальсанд нэвтэрсэн шархтай
- тархины хатуу хальсанд нэвтрээгүй шарх
- галт зэсвгийн үйлчлэлээр үүсгэгдсэн шарх гэх мэт

Тархины хатуу хальс гэмтээгүй бол тархи, ховдлуудад халдвар орох нь харьцангуй бага, хальс урагдсан бол тархи ховдлуудад халдвар орж буглаа, менинго энцефалит болж хүндрэх аюултай.

### **III. Гавлын суурь ясны гэмтэл:**

Гавал тархины хүнд гэмтэл, тархины няцрал, цус харвалттай хавсарсан байдлаар тохиолдоно.

**Тархины доргилт:** Тархи доргих нь гэмтлийн улмаас тархинд рефлектор замаар эсийн молекулын өөрчлөлт, хямрал болж үүнтэй холбоотойгоор амьсгал, зүрх судасны хэвийн үйл ажиллагааны түр зуурын саатлын шинжүүд, хэсэг хугацаанд ухаан алдалтаар,

/15 минут/ амнези илэрнэ. Энэ нь гэмтэх үед буюу гэмтлийн дараахан болсон явдлыг мартаж хэлбэрээр илэрнэ, ухаан орсны дараа толгой өвдөнө, бүх бие нь суларч чих шуугина, толгой эргэнэ, огиулж бөөлжинө, арьс цайна, бие суларна, хүүхэд бол тайван биш нойргүйднэ.

**Тархи няцрах:** Тархи няцрал нь хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрүүдээр дарагдалгүй эсвэл дарагдалтай хавсран явагддаг.

Тархины эдийн няцралын үед үйл ажиллагааны сэргэшгүй өөрчлөлт явагдана. Гавлын яс хагарсан юм уу нугасны шингэнд цус орсон байвал тархины няцрал гэж үздэг. Тархины няцралын үед их тархины бор гадар түүний доорхи төвүүдэд нэг болон олон тооны голомтот өөрчлөлт, үүнтэй холбоотой эмнэл зүйн шинж илэрнэ. Шууд гэмтлийн механизмаар үүсгэгдэхийн зэрэгцээгээр эсрэг талд нь няцарсан голомт үүснэ.

Тархины няцралын хөнгөн хэлбэрийн үед 1-2 цагаар ухаан алдана, тархины голомтот шинж нүүр ам муруй шинж илрэх боловч хэд хоногийн дараа арилна. Эдгээр тархины суурийн гэмтлийн хам шинж хурц үедээ амь насанд аюултай, мөн гавалын яс хугарах, тархинд цус харвахтай хослон явагдана.

**Гавлын яс хугарах** - гавлын оройн ясны хагарах нь тархины няцралтай хам явагдана. Хөндлөн, дагуу хэлбэрээр хагардаг. Рентген 2-3 хэлбэрийн зураг авалтаар оношийг бататгана. Хүүхдэд унтуулж рентген зураг авахгүй бол хөдөлгөөн ихтэй учир төвөгтэй. Гавлын суурь ясны хугарлын урд, дунд, арын хонхорын гэж хуваагдана Урд хонхор хагарвал нүд тойрон хохөрч хавагнадаг, хонхороор тархи нугасны шингэн, цус гарна Дунд хонхорын хугарлын үед дунд чихнии хэнгэрэг хагарч чихээр цус, тархи, нугасны шингэн гарна.



Арын хонхрын хугаралд толгойн хөхлөг сэртэнгийн түвшинд цус хурах нь олонтой. Тархи дарагдах: гэмтлийн шалтгаантай дарагдал

1. тархинд цус хурах
2. гавлын оройн яс цөмрөх
3. тархи хавагнах

Тархинд цус хурж тархи дарагдахад хамгийн их үхэлд хүргэдэг гэмтэл, тархи няцрахтай хослон явагдвал шууд ухаан алдана, ихэнхдээ гэмтлийн дараагаар ухаан сэргээд дахин ухаан алдах, эсвэл эхлээд ухаантай байгаад дахин ухаан алдах, бөөлжих нь зогсож бие нь сайжрах маягтай болсноо дахин огиулж бөөлжиж эхлэнэ, цусны даралт харьцангуйгаар ихсэж болно. Ялангуяа цус харвасан талдаа, хөөрөлтийн байдалтай, тархины хатуу хальсны дотор цус харвалтын үндсэн шинж илэрнэ. Гэвч хэсэг хугацаа өнгөрсний дараа хөөрлийн шинж илэрвэл тархины цус харвасан байж болно.

Хожуу хугацаанд хурсан талдаа хүүхэн хараа өргөснө, зовхи унжиж эсрэг талдаа саа үүснэ, хатуу хальсны гадна цус хурахад голомтот шинж богино хугацаанд илэрнэ. Хатуу хальсны дотор цус хурахад голомтот шинж аажмаар гүнзгийрч тархины хатуу хальсны дор цус харвалт өгнө, Ихэвчлэн тархины няцралтай хам явагдана. Цус хурсан талдаа толгой өвдөнө. Тархины дотор цус хуралтын үед хуурамч сайжрал, ухаан алдалт нь аажим гүнзгийрнэ, гол төлөв таталт үүснэ. Тархины доторхи цус хуралт нь эмнэл зүйн шинж олон янз, хатуу хальсны гадна, дотор цус хуралтын шинж илэрнэ, тархи хавагналтын шинж нь тархины хавангийн эсрэг эмчилгээнд аажмаар сайжирч засал авч эхэлнэ.

**Тархины гэмтлийн оношлогоо:** Тархины хүнд гэмтэлтэй, өвчтөн ухаан алдаж, зүрх судасны цочмог дутмагшилд орох учир эхний ээлжинд амьсгал, зүрх судасны үйл ажиллагааг дэмжих, сэргээх эмчилгээг яаралтай хийгээд оношлогоог тодруулна.

Ухаан алдалтыг 4 зэрэгт хуваана.

Муужралт: нүд эрээлжлэн, чих шуугин, түр зуур ухаан алдана, асуусан асуултанд удаавтар хариулна.

Нойрмоглолт: Унтаа байдалтай, орчноо муу мэдэрч, асуусан асуултанд ганц нэг үгээр удаан хариулна.

Унталт: /сопор/ асуултанд хариулахгүй, орчноо мэдрэхгүй, бүх булчин нь суларч рефлекс арилна, залгих рефлекс байна, дорой дуугаар ёолох, гар хөлөөрөө түлхэж эсэргүүцнэ.

Оврого: Ком гаднын ямар ч цочролд хариу өгөхгүй, бүх булчин суларсан, залгих рефлекс байхгүй, амьсгал, зүрх судасны үйл ажиллагаа эрс суларна.

Гавал, тархины гэмтлийн үед 12 хос мэдрэлийн гэмтлийн ерөнхий, голомтот шинжүүд илэрнэ. Энэ нь гавал ясны хагарал, тархины гэмтлийн байрлалыг тогтоох баттай шинжүүд юм.

Ерөнхий шинж: Огиулж бөөлжих, толгой өвдөх, эргэх, судасны лугшилт удаашрах Голомтот шинжүүд нь: хөл гарын саажилтаар илэрнэ, хүнд гэмтэлтэй, согтуу хавсарсан бол энэ шинж тэмдгийг илрүүлэхэд төвөгтэй, өвдөг түнхээр нугалж хөлний улнаас гараар дэмжихэд хөл тэр байрлалдаа тогтож байвал саа, саажилтгүй, хүүхэнд хараа нэг талдаа өргөсөж хэлбэр нь алдагдсан, гэрлийн урвал байхгүй болно.

Нүдний хүүхэн хараа нэг талдаа өргөсөн хэлбэр дүрс нь алдагдсан бол их төлөв тэр талдаа тархины няцрал буюу цус хуралт, хэрэв 2 талдаа өргөсөөд хавангийн эсрэг эмчилгээнд үр дүнгүй бол тархины суурийн гэмтэл байх ба ихэвчлэн тавилан муутай.

### **Нугасны гэмтэл:**

Нуруу хугарахад нугас доргих, няцрах, нугасанд цус хурах - хатуу зөөлөн бүрхэвчийн гадуур, дотуур цус хуралдсан, нугас гүйцэд буюу бүтэн тасарсан байна. Иймд нурууны хугаралтай өвчтөнд нугасны мэдрэлийн хямрал байгаа эсэхийг тэр даруйд шалгаж үзэх хэрэггүй. Эхний үед ямар гэмтэл учирсныг тогтооход төвөгтэй боловч хагас гүйцэд тасарсныг оношлох боломжтой.

Нугас доргисон үед хөл, гарт саа илэрнэ, мэдрэхүй алдагдана, 2-3 хоног, хэдэн цагийн дараа арилна, нугас няцрахад мөчдөд саа, саажилт илэрнэ, аарцгийн эрхтний үйл ажиллагааны хямрал илэрнэ, нугасны шингэн цустай гарна, рентген шинжилгээнд нурууны нумын болон нугалмын их биений хугарал харагдана.

Нугасны цагаан бодис цус харвах, (гематомиелия) сээрний, бүсэлхийн эрхтний үйл ажиллагааны хямрал тохиолдоно. Гэмтсэн гар хөл огт хөдлөхгүй болсон байвал гүйцэд тасарсан байж болзошгүй, гэмтэл учирснаас хойш мэдээ хөдөлгөөн муудсаар мэдэрхүй хөдөлгөөн огт байхгүй болох олон янзын шалтгаанаас нугас дарагдсанаас болдог, үүнтэй зэрэгцээгээр арьсанд холголт, цооролт үүснэ. Нугас бэртсэн, доргисон, хавангаас үүссэн хямрал өөрчлөлт яваандаа арилдаг. Нугас гүйцэд тасрахад үйл ажиллагаа сэргэхгүй боловч асаргаа, сувилгаа, эмчилгээ чиг бэхэлгээ сайн байгаад ялангуяа үйл ажиллагааг орлуулан хөгжүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээ, сэтгэл засал сайн байвал өвчтөн өөртөө үйлчлэх, зарим нэг хөдөлмөр хийх чадвартай болдог.

### **Тархины гэмтлийн эмчилгээний ерөнхий зарчим:**

Гавал, тархины хүнд, хөнгөн аль ч :-хэлбэрийн үед хэвтрийн дэглэм сахиулна. Тархи доргисон 3-10 хоног тархи няцрал, хүнд.


хүндэвтэр 2-3 долоо хоног, хүнд хэлбэрийн няцрал 3-4 долоо хоног суурийн гэмтлийн үед

5 долоо хоног хэвтрийн дэглэмд толгойд мөсөн жин тавибал зохино.


Тархины доргилтын үед парацетамол 0.5, седуксин 0.3, люминол 0.05 зэрэг эмийг биеийн кг жинд 2 мл-ээр бодож хийнэ.


Тархины хүнд гэмтлийн үед: өвчтөнг хэвтрийн дэглэмд байлган, амьсгалын замыг чөлөөлж соруулалт хийж, толгойд мөсөн жин тавина, ухаангүй маш хүнд өвчтөнд трахеостомия тавьж хүчилтөрөгч амьсгалуулна, Артерийн даралт буурсан үед ганглиоблокаторууд, аминазиныг болгоомжтой хэрэглэнэ. Цус тогтоох зорилгоор аминакапроновая кислота, 10% кальцглюконатыг судсанд тарих нь зүйтэй. Тархинд цус хурсан нөхцөлд цаг алдалгүй мэс заслын эмчилгээ (трепанация) хийх ёстой. Тархи нугасны гэмтэлтэй өвчтөнд сүүлийн үед барокамерт оруулах эмчилгээ явуулж байна.

### *Зураг 22. Нурууны гэмтэл авсан хүнийг зөөвөрлөх*



1. Гэмтсэн хүнийг зөв байрлалд оруулна.






3. Гэмтсэн хүнийг тээвэрлэх хатуу хэрэгслийг зөв байрлуулах



4. Гэмтсэн хүнийг шулуун байрлалд эргүүлэх



5. Гэмтсэн хүнийг тээвэрлэх хатуу хэрэгсэл дээр байрлуулах

6. Гэмтсэн хүнийг зөв тээвэрлэж эмнэлэгт хүргэх

Гэмтсэн хүний толгой нурууг гулзайлгахгүй, хос тэнхлэгт авч явах хэрэгтэй

**АНХААР!**

Нурууны гэмтэлтэй хүнийг зөөвөрлөхдөө заавал хүзүүнд нь хүзүүвчийг зүү

## ДОЛОО. ҮЕНИЙ МУЛТРАЛ

Үе мултрал нь гэмтлийн дотор 1.5-3%-ийг эзэлнэ. Үе үүсгэж байгаа яснуудын харьцаа алдагдахыг хэлнэ. Дээд мөчний мултрал 7-8 дахин илүү тохиолдоно. Мултралын үед үений холбоос, шөрмөс, булчин сунах, тасрах, зарим тохиолдолд том судас, мэдрэлийн судал гэмтэх. ясны хугаралтай хам, хүндрэлтэй хэлбэрээр тохиолддог.

1. Үений гадаргуунуудын харьцаа хир алдагдсанаар: а. бүрэн мултрал, б. Бүрэн бус мултрал
2. Шалтгаанаар нь: а. төрөлхийн, б. олдмол, гэмтлийн улмаас, эмгэгийн улмаас
3. Гэмтлийг хугацаагаар нь: а. шинэ мултрал - 3 өдөр хүртэл, б. шинэвтэр - 3 өдрөөс 2-3 долоо хоног, в. Ужиг - 3 долоо хоногоос цааш /энэ бол харьцангуй хугацаа юм Жишээ нь: түнхний үений мултрал 7 хонсг болоход ужиг мултралд тооцно/. г. Сурмаг мултрал: Төрөлхийн мултрал ихэвчлэн түнхний үенд нэг болон 2 талын байна. Эрт оношлох нь эмчилгээний их ач холбогдолтой, хүүхэд хөлд орохдоо доголж явна. Тэр талдаа мөч богиносоно 2 талын түнхний үе мултрахад савлаж явдаг Оношийг рентген зураг авч тогтооно.

Эмгэг өвчний улмаас үе мултрах нь хавдар, сүрьеэ, үений идээт үрэвсэл, үе үүсгэгч ясны үрэвсэл, булчингуудын саа, саажилт зэргээс шалтгаалан бүрэн, бүрэн бус мултрал тохиолдоно.

Ер нь үений мултралын 85-90% нь гэмтлийн шалтгаантай байдаг. Дээд мөчний мултрал 7-8 дахин их тохиолдоно.

Оношлогоо:

1. Ямар ч мултралын үед захын цусан хангамж,

мэдрэлжүүлэлт, арьс зөөлөн эдийн байдлыг нарийвчлан шалгана.

2. Үе аль тал руугаа мултарсныг гэмтлийн үзлэг, шинжилгээнүүдийн үндсэн дээр бүрэн тогтоох, ямар аргаар оруулах, гарч болох хүндрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн авахыг шийдвэрлэнэ.
3. Мултралын үед заавал 2 чиглэлээс рентген зургийг 2 тусгалаас авна.

#### **Шинж тэмдэг:**

Үеэр хүчтэй өвдөх, хөдөлгөөн хийх гэж оролдоход өвдөлт ихсэнэ. Мултарсан хэсгээрээ албадмал байрлалд байна, мөчдийн урт болон тэнхлэг өөрчлөгдөнө, үений хэлбэр дүрс өөрчлөгдөнө, чөмөгний толгой, үений тогоо тус тэмтрэгдэнэ, үений идэвхтэй, идэвхгүй хөдөлгөөн алдагдана. Ямар нэг хөдөлгөөн хийх гэж оролдоход пүрш мэт эсэргүүцэлтэй байна. Энэ нь хүчээр хөдөлгөөн хийх оролдлого хийхэд буцаж байрандаа орж байдаг.

#### **Эмчилгээ:**

1. Оношийг бүрэн тогтоосны дараа мултралыг оруулна.
2. Мултралыг хэсгийн болон ерөнхий мэдээгүйжүүлэлттэй засна. Бололцоотой бол булчин сулруулагч эм хэрэглэнэ. Мэдээгүйжүүлэлт муу хийснээс орчны зөөлөн эд холбоос, мөгөөрс дахин гэмтэж хүндрэл үүсэх, заримдаа мэдрэлжилт, цусан хангамж хямарч тэжээлгүйдэл үүсэх, сорвижих, үений хөдөлгөөн хязгаарлагдах, сурмаг мултрал болох, артроз үүсэх зэргээр тахир дутуу болохын үндэс болдог.
3. Мултралыг тэр даруйд нь засах шаардлагатай. Засалтыг цаг тухайд нь хийгээгүйгээс үе мултарсан байрлалдаа хэвшиж үений уут орчмын зөөлөн эд сорвижих үений тогоо сорвиор дүүрч мөгөөрс нь гөлгөр чанараа алдаж зөөлөрснөөс үений ажиллагаа алдагдаж анатомийн өөрчлөлтөд ордог.

4. Мултралыг эвд нь оруулсны дараа физиологийн дундаж байрлалд оруулж байрлуулж бэхэлнэ. Ингэснээр урагдах сунасан үений уут эдгэрч үений хөдөлгөөн хэвийн сэргэнэ. Мултралыг аль үенийх, хүндрэлтэй эсэхээс шалтгаалж 14-60 хоног бэхэлгээ хийх шаардлагатай.
5. Мултралыг эвийн аргаар засаж чадаагүй, мултрал ужиг болсон, сурмаг мултралыг мэс заслын аргаар эмчилнэ.

#### **Эгэмийн мултрал:**

Бүх мултралын дотор 5%-ийг эзэлнэ. Гадна, дотор үзүүр хэсгийн мултралыг ихэвчлэн гадна үзүүрийн мултрал эзэлдэг. /далны их шонтонгоос/ бүрэн, бүрэн бус мултрал тохиолдоно. Эгэмийн гадна үзүүрийн мултрал эгэм, далны их, бага шонтонгийн, эгэм хавирганы холбоосууд тасарвал бүрэн мултрал болдог, бүрэн бус мултралд далны бага шонтон эгэмийн холбоос бүтэн үлддэг. Оношлоход хялбар боловч эмчлэхэд төвөгтэй. Эвийн эмчилгээ үр дүнт муутай, бүрэн биш мултрал, мөн үйл ажиллагааны алдаагүй бол эвийн эмчилгээ хийнэ. Үений хэлбэр өөрчлөгдсөн, өвдөлттэй, үйл ажиллагааны өөрчлөлттэй бол мэс заслын аргаар эмчлэнэ. Мэс заслын явцад сорвижсон эдийг сайтар өөлж аваад мултралын үзүүрүүдийг ган нийлэг утсаар эгэм, далны бага шонтонгийн холбоостой цуг сэргээж бэхэлнэ. Цээжийг гартай бэхэлсэн гөлтгөнөн боолтыг 4-6 долоо хоног тавина. Эгэмийн дотор үзүүрийн мултралыг гуяны шар хальс, нийлэг утсаар эгэм хавирга, эгэм өвчүүтэй бэхлэх хэлбэрээр холбоосыг сэргээнэ.

#### **Мөрний үеэр мултрах:**

Бүх мултралд 50-60%-д тохиолдоно. Энэ үе



анатоми, физиологийн онцлогтой ба далны тогоо атгаал чөмөгний толгой тохиромж муутай 1/б-ээр хүрэлцэж байдаг гол тулгуур нь хүчтэй богино булчингууд байдаг учир булчингийн үе ч гэж нэрлэдэг ёс бий. Бүх чмглэлийн хөдөлгөөнийг өргөн хэмжээгээр хийдэгтэй холбоотой.

### **Шинж тэмдэг:**

Гэмтэгч шуугаараа гараа унжуулсан, гэмтсэн тал руугаа хазайсан, эрүүл гараараа өвчтэй гараа барьсан чөмөгний толгой доошоо /суга руугаа/ мултарсан бол мөч уртассан юм шиг, мөрний үеэр суга тэнийсэн Дельта хэлбэрийн булчингийн хэсэгт хонхойсон, Цээжний том булчингийн дор, суганд чөмөгний толгой тэмтрэгдэнэ.

Чөмөгний толгой урагш мултрахад үений урд далны хошуу сэртэн, эгэмний дор тэмтрэгдэнэ. Чөмөгний толгой арагш мултрахад үений тогооны ард далны хонхорт тэмтрэгдэнэ. Рентген 2 тусгалын зураг авч ясны хугаралтай хавсарсан эсэх болон оношийг зөв тогтооно.

### **Эмчилгээ:**

Шинэ шинэвтэр мултралыг тэр даруйд нь болон ерөнхий мэдээ алдуулалттайгаар нь оруулна. Мултралыг оруулахдаа Гилпократ, Джаннелидзе, Кохерын аргаар оруулна. Эвд оруулсны дараа шалгалт рентген зураг 2 тусгалаас авна. 3 долоо хоног гөлтгөнөн тавина. Хөдөлмөрийн чадвар 35-40 хоногийн дараа сэргэнэ. Ужиг мултралыг мэс заслын аргаар эмчилнэ.

### **Мөрний сурмаг мултрал:**

Гэмтлийн шалтгаан мултралд 2-16%-д тохиолдоно. Сурмаг мултрал үүсэхэд атгаал чөмөгний их төвгөр дайрсан хугарал, далны тогооны ирмэг сэтэрсэн хугаралтай хавсарсан, үеийг бэхлэгч мөрний бүслүүрийн булчингуудын дутуу хөгжил, мэдрэлжилтийн

хямралтай, мултралыг эвд нь оруулахдаа мэдээгүйжүүлэлтийг буруу сонгож авсан, чиг бэхэлгээг цөөн хоног хийсэн зэрэг шалтгааныг хамааруулан судлаж байна.

**Шинж тэмдэг:** Анхны мултралаас хойш 7-8 удаа мултарвал сурмаг мултрал гэж үзнэ. Бабигийн шинж: Мөрний үеэр идэвхгүй хөдөлгөөн алдагдсан /энэ дахин мултрахаас болгоомжилсон/

**Ороботуна шинж:** мултардаг талын далны өнцөг эрүүл талаасаа дор байрлалтай Ванштейны шинж: мөрний үеэр суга өргөсөн байрлалд алга тосох идэвхтэй **үйл** ажиллагаа алдагдана.

**Эмчилгээ:** Мэс заслын 250 орчим арга байдгаас аль хөнөөл бага учруулдаг, үр дүн сайтай аргуудыг сонгон авах, мэс заслын дараа тохойн үеэр нугалан цээжийг гартай бэхэлсэн Дезо боолтыг 21 хоног бэхэлж боолтыг авсны дараа дулааны эмчилгээ, аажмаар болгоомжтойгоор мөрний үеэр өөрөөр нь идэвхтэй хөдөлгөөн хийлгэнэ. 1 жил хүнд хөдөлмөр, үений хэт хөдөлгөөнийг хийхгүй байх шаардлагатай.

### **Тохойн үений мултрал:**

Бүх мултралын дотор 18-27% эзлэнэ.

1. 2 ясны мултрал /шуу яс, богт чөмөг/. а арагш, б. дотогш, в. Гадагш, г. Урагш, д. Салгуу
2. Шуу яс дангаар мултрах: а. урагш, б. арагш, в. Гадагш
3. Богт чөмөг дангаар мултрах: Эдгээр хэлбэрийн мултрал дотор арагш мултрал 90% хүртэл тохиолдоно. Тохойн үений мултрал үе үүсгэгч яснуудын мултралтай хам тохиолддог.

### **Шинж тэмдэг:**

Тохойн үеэр хүчтэй өвдөнө. Өвдөлт нь хуруу руу дамжина. Тохойн үе атгаал чөмөгний

харьцаа алдагдана. Гютера гурвалжин өөрчлөгдөнө. /Залаа сэртэн, атгаал чөмөгний дотор, гадна булууны ижил хажуут гурвалжин үүсэх ёстой/.

Үеэр урагш мултрахад уртассан, арагш мултрахад богиноссон мэт болно. 2 тусгалаас рентген зураг авч оношийг тогтооно. Сарвууны мэдэрхүй, шуу, богтны тараагуур судасны лугшилтыг шалгах нь зүйтэй.

Тохойн мултралыг тэр дор нь засахыг эрмэлзэх хэрэгтэй. Хэсгийн болон ерөнхий мэдээ алдуулалтыг сонгоно. Ерөнхий мэдээ алдуулалт хийвэл бүр сайн. Мултралыг эвд нь оруулсны дараа гөлтгөнөн аравч тавьж 7-12 өдөр бэхэлгээтэй байлгах, дараа нь сэргээн засах эмчилгээ хийнэ. Хөдөлмөрийн чадвар 20-30 өдрийн дараа сэргэнэ.

#### **Бугуйн үений мултрал:**

Хүчтэй холбоосоор бэхлэгддэг учир мултрал ховор тохиолдоно. Ихэвчлэн шуу хугаралтай хэсэг, шуу ясны ирмэг, шөвөг сэртэнгийн хугаралтай хавсран тохиолдоно. Сарвуу ихэвчлэн арагш, хааяа алган талдаа мултрана. Бугуйн үеэр хэлбэр дүрс нь алдагдах, хавагнах, өвдөх, шуу бугуйн үеэр идэвхтэй, идэвхгүй хөдөлгөөн алдагдах шинж тэмдэг илэрнэ. Оношийг 2 тусгалаас авсан рентген зургаар тогтооно. Мултралыг тэр дор нь ерөнхий болон хэсгийн мэдээгүйжүүлэлттэй засна. Мултралыг нь оруулаад 1400 байрлалд алганы дундаас тохойн үе хүртэл гөлтгөнөн аравч 14 хоног тавина. Хөдөлмөрийн чадвар 30-35 хоногийн дараа сэргэнэ.

#### **Түнхний үений мултрал:**

Бүх мултралын дотор 3-7% эзэлнэ. Шууд биш гаднын хүчний үйлчлэлээр мултрана. Түнхний үе анатомийн бүтцийн хувьд дунд

чөмөгний толгой, уений хонхорт гүн суусан хүчтэй холбоос, булчингуудаар бэхлэгдсэн байдаг тул их хүнд механизмаар үүсгэгдэнэ Түнхний мултралыг үндсэн 4 хэлбэрт ангилна.

1. Арагш дээш мултрах - ташааны мултрал гэж нэрлэнэ.
2. Арагш доош мултрах- суудлын мултрал
3. Дээшээ урагш мултрах - умдагны дээд мултрал
4. Урагш доош мултрал - сүүжний нүхний мултрал гэж ангилна.

### **Шинж тэмдэг:**

Хүчтэй өвдөнө. Арагш дээш мултрахад ташааны үеэр бага зэрэг нугалан хавчих байрлалтай дотогш хөл эргэсэн байдалтай. мөч богиносон их эргүүлэг Розер-Нелатоны шугамаас дээш байрлалд /энэ шугам хэвийн үед суудаг яс, ташаа ясны урд дээд төвгөрийг холбосон шугам, их эргүүлгийн толгойг дайран өнгөрөх ёстой./ цавины холбоосонд тэмтрэхэд хонхор тодорхойлогдоно. Өгзөг хэсэг зузаарсан өргөссөн юм шиг энэ түвшинд тэмтрэхэд дунд чөмөгний толгой тэмтрэгдэнэ.

Арагш доош мултрахад: дээш мултрахаас ялгаатай нь үеэр хурц өнцөг үүсгэн нугалсан. дотогш хөл бага зэрэг эргэсэн сүүжний тогооны ард толгой тэмтрэгдэнэ.

Урагш дээш мултрахад: үеэр тэнэгэр бага зэрэг алцайж, хөл гадагш эргэсэн байрлалтай байна. Цавины холбоосонд тэмтрэхэд чөмөгний толгой тэмтрэгдэнэ. Их эргүүлэг тэмтрэгдэхгүй мөч богиносон хөл хөхөлбий туяатай судас дарагдсан байх нь элбэг тохиолдоно.

Урагш доош мултрахад: Хөл нилээд гадагш эргэж алцайсан байрлалтай, их эргүүлэг тэмтрэгдэхгүй, рентген зургийг 2 тусгалаас авч оношийг тогтооно.

### **Эмчилгээ:**

Мултралыг тэр дор нь ерөнхий унтуулгатайгаар засна. Гипократ Кохер болон 1Коломбо - Смитсон - Джанеладзийн аргаар ясны татлага хийнэ. 3-4 кг ачаа зүүж 3-4 хоног хэвтүүлж, дараа нь гөлтгөнөн коксит тавьж суга таягтай явуулж, 9-10 кг ачаалалтай явуулж 3-н сарын дараа хөдөлмөрийн чадвар сэргэнэ. Энэ дэглэмийг баримтлахгүй бол артроз, дунд чөмөгний жинсэгний үжилгүй үхжил үүсэх хүндрэл тохиолдоно. Засагдахгүй мултралыг мэс заслын аргаар эмчилнэ. Өвдөгний үений мултрал

Бүх мултралын дотор 1 % эзэлнэ. Энэ үе бүх холбоосуудаар бэхлэгдэх учир мултрал ховор тохиолдоно.

Шилбэ: Урагш, арагш, дотогш, гадагш мултрал.  
Ихэвчлэн урагш мултрал тохиолдоно.

Шинж тэмдэг: Өвдөгний үений хэлбэр дүрс алдагдана. Мөчний зах хязгаар хөхөлбөр өнгөтэй, хавантай өвдөгний үений идэвхтэй, идэвхгүй хөдөлгөөн алдагдана. Тэр талын доод мөч богиноссон, тавхайн судасны лугшилтыг тодорхойлох хэрэгтэй. Эцсийн оношийг 2 түсгалаас /эгц, хажуу/ рентген зураг авч тогтооно.

Эмчилгээ: Ерөнхий унтуулгатай засна. Мултралыг эвд нь оруулсны дараа үений хендийд хурц цусыг соруулж авна. 10-12 долоо хоног гөлтгөнөн аравч эмчилгээг явуулна.хөдөлмөрийн чадвар 3-4 сарын дараа сэргэнэ.

### **Тавхайн мултрал:**

Бүх мултралын дотор 3%-ийг эзэлнэ. Мултрал нь ихэвчлэн хавчаар яс, шаант чөмөгний урд, арын ирмэг салсан хугарлууд, шилбэний ясны төгсгөл хоорондын үелэмж салахтай хавсран тохиолдоно. Арагш, урагш, гадагш, дотогш, дээш мултрал. Ихэвчлэн

арагш, гадагш мултрал тохиолдоно.

Шинж тэмдэг: Шилбэ, тавхайн үеэр хүчтэй өвдөнө. Тавхай гадагш, дотогш эргэсэн байдалтай, үений хэлбэр дүрс алдагдсан, хаван ихтэй хэмжээгээрээ урагш мултрахад томорсон, арагш мултрахад богиноссон. 2 тусгалаас рентген зураг авч оношийг батална.

**Эмчилгээ:** Ерөнхий унтуулгатайгаар засна. Зөвхөн мултралд 14 хоног, гадна хавчаар ясны зөрөөгүй хугаралтай хам бол 4 долоо хоног, зөрөөтэй бол 6-7 хоног, гадна хавчаар ясны зөрөөгүй хугаралтай бол 6-7 долоо хоног. зөрөөтэй бол 8-9 долоо хоног, Десто маягийн хугарал мултрал /дотор, гадна хавчаар яснуудын хугарал, шаант чөмөгний арын ирмэг тасарч хугарахад доод шаант, тахилзуурын үелэмж холбоос салсан/ бол 10-12 долоо хоног гөлтгөнөн бэхэлгээ хийсний дараа сэргээн засах иж бүрдэл эмчилгээг явуулна. /дулааны эмчилгээ, илллэг, үеэр идэвхтэй хөдөлгөөн, бүрэн ачаалалтай явах/

Үений мултралыг эвийн аргаар засах аргууд:

1. Оношийг бүрэн тогтоосны дараа мултралыг эвд нь оруулна.
2. Мултралыг тэр даруйд нь эвд нь оруулах шаардлагатай, хэрэв засахгүй мултарсан байдалд дассан үений уут орчмын зөөлөн эд сорвижиж үе үүсгэдэг элементүүд эргэх өөрчлөлтөнд орж засрашгүй согогийг үүсгэдэг.
3. Мултралыг эвд нь оруулсны дараа физиологийн дундаж байрлалд бэхэлгээ хийнэ.
4. Мултралыг эвийн аргаар эвд нь оруулж чадахгүй бол нарийн мэргэжлийн эмнэлэгт хандаж эвд оруулахыг чухалчилна. Болохгүй бол оношийг нарийн тогтооно. 5 хэсэг газарт ерөнхий мэдээгүйжүүлэлтийг хэрэглэнэ. / мэдээ алдалтгүйгээр оруулж болохгүй/

### **Мөрний мултралыг засах:**

Мөрний мултралыг засах олон аргууд байх боловч Кохер, Гиппократ, Джанелидзегийн аргуудыг өргөн хэрэглэж байна.

Кохерын арга: Мултралыг 4 чиглэлийн хөдөлгөөнт үйлдлээр оруулна. Энэ аргыг ясны хугаралтай хавсраагүй бол урд талын мултралыг засахад хэрэглэнэ.

- Мэс засалч мултралтай талын тохойн үеэр нугалж тохойн үенээс нэг гараараа, бугуйнаас нөгөө гараараа барьж тохойг их биенд наалдуулан доош татахад чөмөгний толгой далны бага шонтонгоос холдож үений тогооны урд талд ирнэ.
- Дээрхи байрлалд гарыг мөрний үеэр гадагш эргүүлэхэд атгаал чөмөгний толгой гадагш эргэж, далны хавтас булчин сунана.
- Дээрхи байрлалыг өөрчлөхгүйгээр тохойг нь их биенд шахаж аюулхай орчимд аваачихад чөмөгний толгой үений тогооны ирмэгт ойртож очно.
- Гарыг мөрний үеэр дотогш түргэн эргүүлж, гарын алгыг эсрэг талын мөрөн дээр шидэж, тохойн доороос огцом өргөхөд чөмөгний толгой үений тогоонд гулсан орно. /Эцсийн үйлдлийг богино хугацаанд хий/

Гиппократын арга: Мөрний үений бүх хэлбэрийн мултралыг оруулна. Мөн чөмөгний толгойн зөрөөгүй, төвгөрүүдийн хугаралтай хавсарсан мултралыг засаж оруулна. Мөн ерөнхий унтуулгатай мултралыг засахад хамгийн тохиромжтой арга. Энэ аргаар мултралыг засахдаа өвчтөнийг дэвсгэртэй нь шалан дээр нуруугаар нь хэвтүүлж мэс засалч мултралтай талд нь 2 хөлөө жийж өвчтөний толгой тийш харж суугаад хөлийнхөө есгийгөөр суганы хонхорын урд ирмэгт тулгуурлаж нэг

гараараа тохойн үений дээд талаас, нөгөө  
гараараа бугуйн үенээс барьж эхлээд гарыг бага

зэрэг гадагш эргүүлэх шулуун чиглэлд аажмаар татаж, чөмөгний толгой үений тогоонд ойртож ирэхийн хамт гарыг их биенд ойртуулах чиглэлээр аажмаар татаж мултралыг оруулна. Джанелидзегийн арга; Энэ аргаар мөрний үшний бүх хэлбэрийн хэсгийн мэдээгүйжүүлэлтээр засах боломжтой. Өвчтөнийг хажуугаар урт вандан ширээн дээр хэвтүүлж, мултархай талын гарын суганд ширээний ирмэгийг тохируулан гарыг сул унжуулна. Толгой дээр нь жижиг ширээ тавьж дэрлүүлнэ. Өвчтөнийг 10-15 минут дээрхи байрлалд хэвтүүлсэний дараа өвчтөний гарыг тохойн үеэр 90 нугалж нэг гараараа тохойн үений хонхор талаас, нөгөө гараараа бугуйн үе орчмоос бариад гарыг доош нь дарж, эхлээд гадагш эргүүлэн, дараа нь дотогш эргүүлэхэд мултрал засагдана.

Мөр мултрахад атгаал чөмөгний их бага төвгөрүүд тасарсан ийм нөхцөлд мултрал засаад гарыг физиологийн дундаж байрлалд гөлтгөнөн боолттой 1-2 сар байлгана.

Атгаал чөмөгний бусад хугаралтай хавсарвал гэмтлийн эмчид шилжүүлнэ. Ийм тохиолдолд мэс заслын эмчилгээ тохиромжтой.

Түнхний үений мултралыг эвд нь оруулах: Ерөнхий эсвэл нугасны хатуу хальсанд мэдээ алдуулах аргыг хэрэглэнэ. Джанелидзе, Кохерын аргаар мултралыг засах аргыг өргөн хэрэглэж, манай оронд мордож оруулах аргыг өргөн хэрэглэж байна.

Джанелидзегийн арга:

Хэсгийн мэдээгүйжүүлэлттэй засаж болно. Өвчтөнийг ширээн дээр түрүүлгэн харуулж хэвтүүлж, аарцаг ясыг ширээний ирмэг дээр тохируулан, мултарсан талын хөлийг 20-25 минут чөлөөтэй унжуулна. Дараа нь эмч хөлийг өвдөгний үеэр атийлгаж бага зэрэг алцайлган дотогш эргүүлээд, доош нь нилээд



хүчтэй дарахын хамт гадагш эргүүлнэ. Мултрал засагдахдаа нур гэсэн чимээ гарна.

Үений хөдөлгөөн чөлөөтэй болно. Умдагны чиглэлийн мултралаас бусад шинэ мултралыг засахад тохиромжтой.

Кохерын арга: Өвчтөнийг гэдрэг харуулан хэвтүүлж, туслагч сүүжний 2 тал дээр дарж аарцгаар хөдөлгөөнгүй байлгаад эмч хоёр гараараа хөлийн шилбэ, өвдөгний орчмоос барьж, түнх өвдөгний үеэр атийлган хөлийг хавчих байрлалаар салтаа тийш нь шахаж гуяыг гадагш нь шилбээр нь хөшиж эргүүлээд дараа нь хөлийг түнхний үеэр тэнийлгэхийн хамт алцайлган дотогш эргүүлнэ. Энэ нь нэмэлт гэмтэл учруулж болдог. /Учир нь мултралтай талын хөлөөр хөшүүрэгдэж мултралыг засдаг учраас/

Мордон оруулах монгол арга: Өвчтөнийг дэвсгэр дээр гэдрэг харуулан хэвтүүлнэ. Эмч мултарсан талын хөлийн хажууд сөхөрч сууна, сөхөрсөн 2 өвдгөө зайтай байлгаж нэг өвдгөө өвчтөний аарцагт тулгана. Эмч бөхийн мөрөн дээгүүрээ өвчтөний мултарсан хөлийг тахимаар байрлуулна. Шилбийг нуруун дээгүүрээ буулгаж эмч бүсээрээ хөлийн шагайнаас оосорлон татаад чанга ороож бүсэлнэ. Эмч өвчтөний мултарсан гуяыг тэвэрч 2 гараагаар аарцгийн шонтон дээр дарж бэхэлнэ, дараа нь гэдийж мултарсан хөлийг нурууны хүчээр татна. Мултрал засагдах чимээ гарна. Үүнд: Арын мултралын үед хөлийг дотогш эргүүлэх буюу урд талын мултралын үед хөлийг гадагш эргүүлнэ. /үүнийг туслагч эмчийн ард зогсож шилбээр уг хөдөлгөөнүүдийг хийнэ/.

Мултралыг засаад 2-3 долоо хоног ясны татлагатай байлгаад сэргээн засах эмчилгээ яаралтай хийнэ. 1-2 сар суга таягтай явна.

Ужиг мултралын үед үеэр хөдөлгөөнгүй болгох мэс засал сүүлийн үед хиймэл үе суулгах /эндопротез/ тавих мэс засал хийгдэж байна.

## НАЙМ. ЯСНЫ ХУГАРАЛ

Тодорхойлолт:

Гадны механик хүч, ясны бүтцийн эмгэг өөрчлөлтийн улмаас ясны бүрэн бүтэн байдал алдагдахыг ясны хугарал гэнэ.



*Зураг 24. Хурууны ясанд чиг тавих нь*


Ангилал:

Ясны хугарлыг хэлбэрээр нь:

- Ил
- далд гэж ангилдаг.

**Ил хугарал гэдэг нь** яс хугарч хугарлын үзүүрүүд нь арьсыг цоолон ил гарч харагдаж байгаа хугарал юм.

**Далд хугарал гэдэг нь** хүчтэй доргилт, битүү гэмтлийн улмаас арьсанд шарх үүсгэлгүй яс хугарахыг хэлнэ. Үүнийг танихад төвөгтэй байдаг. Учир нь хугарлын үзүүрүүд нүдэнд ил харагдахгүй, тэр орчмын зөөлөн эдүүд хавдаж, улайсан, өвдөлт ихтэй байдаг тул үзлэг хийхэд төвөгтэй байдаг.



Зураг 25. А. Б: Хугарлын хэлбэрүүд

Илрэх шинж тэмдэг:

Ямар ч хэлбэрийн хугарлын үед дараах үндсэн шинж тэмдгүүд илэрнэ.

- Өвдөнө
- Хугарсан ясны хэлбэр алдагдана.
- Хугарсан хэсэгт хавдаж, улайж хөхөрнө.
- Тэр орчмын арьс халуун болсон байна.
- Хөдөлгөөн хязгаарлагдана.
- Барьж үзэхэд ясны хавиралдах чимээ сонсогдоно.
- Тэр хэсгийн үйл ажиллагаа алдагдана.

Ямар ч хэлбэрийн хугарлын үед үзүүлэх үндсэн тусламж нь хугарсан ясанд чиг барьж боох явдал юм. Хугарсан хэсэгт чиг тавьж боохдоо маш болгоомжтой хөдөлгөх ба хувцастай тохиолдолд хувцастай нь хамт өргөх хэрэгтэй.

## АНХНЫ ТҮСЛАМЖ

### Хэрвээ ил хугарал байвал:

1. гараа угаана.
2. цус гарч байвал цусыг тогтоона / өмнөх цувралаас үзнэ үү /.
3. шархан дээр цэвэр жийргэвч тавина.
4. боолт хийнэ.
5. хугарсан ясанд чиг тавьж бооно.
6. хугарсан үеийг хөдөлгөөнгүй болгон тээвэрлэхэд бэлтгэнэ / хатуу биет буюу мод төмөр, хатуу цаас зэргийг ашиглаж болно/.

### Хэрвээ далд хугарал байвал:

1. биед ил шарх байгаа эсэхийг сайтар ажиглана.
2. хугарсан ясыг хөдөлгөөнгүй болгож чиг тавьж бооно.
3. биеийн аль нэг хэсэгт өөр ил шарх байвал ариун жийргэвч тавьж боолт хийнэ.

### Чигийг тавихдаа дараах зүйлүүдийг анхаарах хэрэгтэй.

- Чиг нь хугарсан яснаас дээшээ ба доошоо 1-2 үеийг хамарсан байна.
- Чиг нь гулзайж муруйхгүй бат бөх байна
- Чиг нь арьс, зөөлөн эдийг холгохгүйн тулд зөөллөсөн байна.
- Боолтны чанга сулыг тохируулсан байна.

### Чигийг доорх байдлаар тавьдаг.

- Хурууны яс хугарсан тохиолдолд




Зураг 26. Хурууны ясанд чиг тавих нь

- Гарын шууны яс хугарсан тохиолдолд



*Зураг 27. А.Б: Шууны ясанд чиг тавих нь*

- Хөлийн шилбэний яс хугарсан тохиолдолд доорх байдлаар чиг тавьж бооно.



*Зураг 28. А.Б: Хөлийн шилбэний ясанд чиг тавих нь*

## ЕС. ТҮЛЭГДЭЛТ

### Түлэгдэлт гэж юу вэ?

Галын дөл, хэт халуун шингэн, халуун уур, химийн бодис, цахилгаан гүйдэл, цацраг туяа гэх мэт хүчин зүйлийн нөлөөгөөр арьс болон арьсан доорх өөхөн эд, эрхтэн гэмтэхийг ТҮЛЭГДЭЛТ гэнэ.

### Ангилал:

А. Түлэгдэлт нь арьсыг хэр зэрэг хамарсанаас шалтгаалж дараах 3 зэрэг болгон ангилдаг.

Түлэгдэлтийн зэрэг	Арьсыг гэмтээсэн байдал	Илрэх шинж тэмдэг
I зэрэг буюу өнгөц түлэгдэлт	Арьсны өнгөц давхарга гэмтэнэ	-улайна -бага зэрэг хавдана -хорсоно



Зураг 29. А: 1-р зэрэг

II зэрэг буюу хэсэгчилсэн түлэгдэлт	Арьсны өнгөц болон жинхэнэ арьс гэмтэнэ	-улайж хавдана -цэврүү үүснэ -өвдөнө
-------------------------------------	---	--



Зураг 29. Б: 2-р зэрэг

III зэрэг буюу гүн түлэгдэлт	Арьсны бүх давхарга гэмтэнэ	-улайна -хавдана -өвдөлтгүй -арьсны өнгө өөрчлөгдөнө
---------------------------------	--------------------------------	--



Зураг 29. В: 3-р зэрэг

### АНХНЫ ТУСЛАМЖ

Аль ч хэлбэрийн түлэгдэлтийн үед анхны тусламжийн зарчим нь:

- Осол болсон газраас холдуулан
- Түлэгдсэн хэсгийн хувцас, эд зүйлсийг яаралтай тайлж авна / бөгж, цаг, бүс гэх мэт
- Урсгал хүйтэн усан доор 10-20 минут байлгах
- Гар доорхи цэвэр материалаар боолт хийх
- өвдөлт намдаах эм уулгах
  - шокоос сэргийлэх арга хэмжээ авах





Зураг 30. А. Б. В: Түлэгдэлтэнд үзүүлэх тусламж

**Хориглох зүйл:**

- Түлэгдсэн хэсэг дээр цас, мөс тавих.
- Түлэгдсэн хэсэгт үүссэн цэврүүг хагалах
- Түлэгдсэн хэсэгт наалдсан хувцасыг хуулах
- Түлэгдсэн хэсэг дээр хөвөн материал тавих

Галын дөлд түлэгдэж байгаа тохиолдолд:

**Зогс - Хэвт - Өнхөр**

гэсэн дарааллаар тусламж үзүүлнэ.



Зураг 31. Зогс, хэвт, өнхөр



Цахилгааны түлэгдлийн үед:

- Аюулаас холдуулна
- резинэн бээлий өмсөж цахилгааныг салгана
- цахилгаан гүйдлийг салгах боломжгүй бол цахилгаан дамжуулахгүй зүйлээр хүнээ холдуулна / мод /
- Тайвшруулна.
- Яаралтай эмнэлэгт хүргэнэ.


## АРАВ. НАМ ТЕМПЕРАТУРЫН НӨЛӨӨГӨӨР ҮҮСЭХ ЭМГЭГ

**Нам температурын улмаас эмгэг байдал хэрхэн үүсэх вэ?**

- Хүйтэн орчинд удаан хугацаагаар байх
- Агаарын чийгшил их, салхитай байх
- Хөгшин хүн
- Бага насны хүүхэд
- Зохисгүй хувцаслалт /нимгэн, нийлэг материалаар хийгдсэн хувцастай байх/
- Хоол тэжээлийн хомсдол
- Хөдөлгөөний дутагдал
- Архи хэтрүүлэн хэрэглэх
- Төрөл бүрийн гэмтэл /шарх, цус алдалт/

Нам температурын үйлчлэлийн үед хүний биеийн дасан зохицох чадварын нөлөөгөөр цусны судсууд агшиж дулаан ялгаралтыг хэсэг хугацаанд багасгах ба энэ нь удаан үргэлжилбэл хүний эд эрхтэнд эргэшгүй өөрчлөлт гаран улмаар үхэх аюултай.

Нам температурын үйлчлэлийг хөлдөгт, осголт гэсэн 2 янзаар ангилан ойлгож болно.



Зураг 32. Нам

Температурын

үйлчлэл

## ХӨЛДӨЛТ

Тодорхойлолт:

Хөлдөлт гэдэг нь нам температурын улмаас хэсэг газрын арьс, улмаар эрхтнүүдийн цусан хангамж алдагдаж хүйтэнд хайрагдсанаас арьсны бүтэц өөрчлөгдөхийг хэлнэ. Биеийн захын хэсгүүд болох гар хөлийн хуруунууд, чих, хамар, хацар, эрүү, гар, хөлийн үзүүр ихэвчлэн хөлддөг.

Ангилал :

Хөлдөлтийг арьсыг гэмтээсэн байдлаас нь шалтгаалж дараах 3 зэрэг болгон ангилдаг. / арьсны бүтцийг 5-р сэдвээс үзнэ үү /

Хөлдөлтийн зэрэг	Арьсыг гэмтээсэн байдал	Илрэх шинж тэмдэг
I зэрэг	Арьсны өнгөц давхарга гэмтэнэ	-арьсны өнгө цайж, хөхөлбөр туяатай болсон -тэр хэсэг бадайрч
 Зураг 33. А: Хөлдөлтийн 1-р зэрэг		
II зэрэг буюу	Арьсны өнгөц болон жинхэнэ арьс гэмтэнэ	-арьсны өнгө цайж, хөхөлбөр туяатай болсон -цэврүү үүснэ -хавдана
 Зураг 33. Б: Хөлдөлтийн 2-р зэрэг		

III зэрэг буюу	Арьсны бүх давхарга гэмтэнэ	-арьсны өнгө цайж, хөхөлбөр туяатай болсон -цэврүү үүснэ -чинэрч мэдээгүй болно
 <p data-bbox="393 786 874 824">Зураг 33. В: Хөлдөлтийн 3-р зэрэг</p>		

Хөлдөлтийн үед арьсанд гарах дээрх өөрчлөлтүүдээс гадна ерөнхий шинж тэмдгүүд илэрдэг.

**Шинж тэмдэг:**

1. Даарч, чичирсэн.
2. Бүх биеийн болон мөчдийн арьс биржийсэн / галууны арьс шиг/.
3. Судасны цохилт олширсон /1 минутанд 80- аас дээш /.
4. Хөлдсөн хэсгийн арьсыг тэмтрэхэд хүйтэн, хатуурч зузаарсан мэт байна.
5. Мөчид хөлдвөл хөдөлгөөн нь хязгаарлагдана.

## **ОСГОЛТ /биеийн температур буурах/**

Осголт гэдэг нь хүйтэн, нойтон, салхи, шуургатай газар удаан хугацаагаар байснаас биеийн ерөнхий дулаан буурч, бүх эрхтэн тогтолцооны талаас өөрчлөлт гарахыг хэлнэ.

Осголтын үед яаралтай арга хэмжээ авахгүй бол үхэлд хүрэх аюултай.

### ***Осголтыг хэрхэн таних вэ?***

Биеийн температур 33C хүртэл буурах :

- Маш их даарч, чичирсэн.
- Арьсны өнгө нилэнхүйдээ цайж, хөхөлбөр туяатай болно.
- Барихад маш хүйтэн байна.
- Хөдөлгөөн хязгаарлагдаж, явах хөдлөхөд бэрхшээлтэй болсон.
- Нүд нь гөлөрсөн.
- Судасны цохилт цөөрсөн / 1 минутанд 60- аас доош /
- Нойр их хүрч, нойрмоглоно.
- Ухаан санаа өөрчлөгдөнө.

Харин биеийн температур 30C хүрч буурахад ухаан алдаж үхэлд хүрдэг.

## **АНХНЫ ТУСЛАМЖ**

- Амьсгал, судасны цохилтыг шалгана.
- Гэмтсэн хүнээ салхи, бороо, цасан шамарга чийгтэй орчноос холдуулж хуурай, дулаан газар аваачина.
- Хөлдөж осгосон хүнийг аль болох өөрөөр явуулахгүй, хөдөлгөхгүй байхаар зөөвөрлөнө.
- Хөлдөж осгосон хүнийг босоо байрлалд байлгана.
- Хүйтэн, нойтон хувцсыг тайлна.
- Дулаан хөнжилөөр хучиж хэвтүүлнэ.
- Дулааныг барихын тулд толгойг хучина.

- Хэрвээ ухаантай байвал халуун юм уулгана.
- Дулаацуулна. 2 янзаар дулаацуулж болно.
  - шууд биеийн дулаан хэсгээр хүрэлцүүлж Жишээ нь: хөлдсөн гар, хөлийг анхны туслаж үзүүлэгч Та өөрийн биеийн дулаан хэсэгт наан дулаацуулах /суга, хэвлий гэх мэт/, хамар, чих хөлдвөл дулаан гараар барьж дулаацуулах.
  - гадны зүйлээр буюу бүлээн жин, шилтэй ус зэргийг том судасны цэгүүд дээр тавих. Хөлдсөн гар хөлийг биеийн дулаантай ойролцоо буюу 36,5-370C -ын температуртай бүлээн усанд дүрнэ. Хөлдсөн хэсгийг аль болох дулаацаж гэтэл дүрнэ.
- Цэвэр боолт хийнэ. Хэрвээ хөл, гарын хуруунууд хөлдсөн бол хуруунуудын хооронд ариун жийргэвч хавчуулж бооно.
- Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж дуудах буюу ойролцоох эмнэлэгт хүргэнэ.

#### **АНХААР!**

Хөлдсөн арьсыг үрж болохгүй, Цахилгаан хапаагуур, ил гал, туяанд ээж болохгүй. Архи уулгаж болохгүй Халуун бүлээн жинг тавихдаа гадуур нь даавуугаар жийрэглэн ороож тавина.



*Зураг 34. А.Б: Хөлдсөн хөлийг боох*

## АРВАННЭГ.ХОРДЛОГО

Хордлого гэдэг нь төрөл бүрийн хортой бодис хүний биед нэвтрэн орж цусаар дамжин бүх эд эрхтэнүүдэд тархсанаас биед гарч байгаа хямралыг хэлнэ.

Хор гэдэг нь хий, шингэн, хатуу зэрэг ямар ч хэлбэрээр байж болох ба хүний биед ороод гэмтэл учруулж цаашлаад үхэлд ч хүргэдэг.

хордлого үүсгэгч хортой бодис нь

- амьсгалын
- хоол боловсруулах
- арьсаар нэвчих
- амьтанд хазуулах, хатгуулах буюу шууд цусанд орох гэсэн 4 замаар хүний биед нэвтрэн ордог.



Зураг 34. А.Б.В: Хордлогын шалтгаанууд

**Хоол боловсруулах замаар хордлого хэрхэн үүсэх вэ ?**

- хугацаа хэтэрсэн буюу муудсан хоол хүнсний бүтээгдэхүүн
- эмийн бодисын тунг хэтрүүлэн хэрэглэх / димедрол, седуксин, парацетамол. аспирин/
- ахуйн хэрэглээний угаалгын нунтаг болон шингэнүүд, хортон шавьж устгах хор
- зарим ургамал / хортой мөөг, жимс / зэргийг ууж идсэнээс болдог.

**Амьсгалын замаар хордлого хэрхэн үүсдэг вэ?**

- карбон монооксидаос үүссэн утаа, өөрөөр хэлбэл машины утаа
- карбон диоксид буюу тэсрэх бодис
- хлор, цацдаг цэвэрлэгч бодис болон хэт хурц үнэртэн зэрэг нь амьсгалын замааг нэвтрэн орсноос үүсдэг.

**Арьсаар нэвчих хордлого хэрхэн үүсэх вэ?**

- Янз бүрийн химийн бодис, угаалгын нунтаг, шингэнүүдийг болгоомжгүй хэрэглэх
- Хортон шавьж устгах хор, бордоо гэх мэтийг хамгаалах хувцас, бээлийгүй хэрэглэх зэргээс үүсдэг.

**Аль ч хэлбэрийн хордлогын үед дараах үндсэн шинж тэмдгүүд илэрдэг.**

- Толгой эргэнэ.
- Толгой өвдөнө.
- Судасны цохилт олширно /1 минутанд 80- аас дээш/.
- Амьсгал олширно /1 минутанд 20-иос дээш/.
- Арьсны өнгө цайж, ам хамрын гурвалжин хөхөрнө.
- Ам хатна.
- Чих шуугина.
- Нүд бүрэлзэнэ.
- Ядарч сульдана.
- Дотор муухайрна.



- Огиулна.
- Бөөлжинө.

Эдгээр шинж тэмдгүүд заавал бүгдээрээ зэрэг илэрдэггүй. Хортой бодис ямар замаар нэвтрэн орсноос шалтгаалж зарим онцлог шинжүүд нэмэгддэг.

***Хоол боловсруулах замаар хордсон үед:***

- Хэвлийгээр өвдөнө.
- Суулгана.
- Эмийн бодис болон бусад ууж идсэн хорт бодисууд амнаас нь үнэртэж болно.
- Угаалгын нунтаг идсэн тохиолдолд бөөлжис нь хөөсөрч гарна.
- Ухаан санаа өөрчлөгдөнө.

***Амьсгалын замаар хордсон үед:***

1. Цээжээр өвдөнө.
2. Амьсгалахад бэрхшээлтэй болно.
3. Утаа үнэртэнэ.
4. Ухаан санаа өөрчлөгдөнө.
5. Ухаан алдана.

***Арьсаар нэвчсэн хордлогын үед:***

1. Арьс загатнана.
2. Арьс улайна.
3. Арьсан дээр тууралт гарна.

**АНХНЫ ТУСЛАМЖ.**

**Хоол боловсруулах замын хордлогын үед:**

1. Хэрвээ ямар нэгэн хортой бодис хэрэглээд удаагүй байгаа тохиолдолд буюу тэр дор нь ойролцоогоор 1,5-2л ус уулгаад хэлний уг дээр дарж бөөлжүүлж болно. Гэхдээ химийн ямар нэгэн бодис уусан болохыг лавтай мэдэж байгаа болон юу уусныг огт мэдэхгүй байгаа тохиолдолд ямар нэгэн уух юм өгч бөөлжүүлж

болохгүй. Шууд эмнэлгийн тусламж дуудах хэрэгтэй.

2. DRABC-г шалга / 2.2 сэдвийг үз/
3. 3.Ойролцоох эмнэлэг болон хордлогын төвөөс тусламж дууд.

**Амьсгалын замын хордлогын үед:**

1. Яаралтай цэвэр агаарт гаргаж шалтгаанаас нь зайлуулах хэрэгтэй.
2. DRABC-г шалга
3. Ойролцоох эмнэлэг болон хордлогын төвөөс тусламж дууд.

**Арьсаар нэвчсэн хордлогын үед:**

1. Хор нэвчсэн хэсгийн арьс салстыг ойролцоогоор 15-20 минут цэвэр усаар угаана.
2. Их хэмжээний уух юм өгнө /буцалсан ус шингэн сэлбэх давс, сүү гэх мэт/.
3. DRABC-г шалга.
4. Ойролцоох эмнэлэг болон хордлогын төвөөс тусламж дууд.



Хэрвээ та хордлогын дээрх  
Шинжүүдээс илэрвэл цаг алдалгүй  
Хордлогын Яаралтай Тусламжийн  
Үндэсний Төв рүү утасдаарай.

Утас: 450097, 453279

Хаяг: Баянзүрх дүүрэг

## **АРВАНХОЁР.НҮДНИЙ ГЭМТЛҮҮД**

Нүд нь хүний хамгийн мэдрэг бөгөөд эмзэг эрхтэн юм. Иймээс хүн бүр нүдээ гэмтээхээс урьдчилан сэргийлж, хамгаалж байх нь чухал. Гэмтсэн тохиолдолд анхны тусламж үзүүлж сурах нь зүйтэй.

Нүдэнд дараах төрлийн гэмтлүүд голдуу тохиолддог.

- нүдэнд гадны биет орох
- нүд түлэгдэх
- нүдний битүү гэмтэл / өндрөөс үсрэх, унах зэрэг тархины доргилт, гэмтлийн үед/

### **Шинж тэмдэг:**

- нүдэнд юм торно.
- юм харж чадахгүй
- зовхи нээгдэхгүй, нүдээ нээхэд бэрхшээлтэй
- нүднээс нулимс гоожно.
- хорсоно.
- өвдөнө.
- гэрэл харж чадахгүй.
- улайна.
- зовхи хавдана.
- 

### **АНХНЫ ТУСЛАМЖ**

Нүдэнд гадны биет орсон тохиолдолд уг гадны биет нь жижиг, нүдний салстыг гэмтээж шарх үүсгээгүй бол ихэнхдээ нүднээс нулимс гарч нүдний алимыг угаан гадны биетийг урсгаж гадагшлуулдаг.

Хэсэг хугацааны дараа дээрх зовиурууд үргэлжилж нүдэнд орсон юм гараагүй бол:

1. Нүдэнд юм торж байгаа эсэхийг лавлана.
2. Гараа савандаж угаана.
3. Нүдний алимыг дээш, доош, баруун, зүүн тийш эргэлдүүлж нүдэнд орсон гадны биетийг олно.

4. Хэрвээ нүдэнд орсон гадны биет нь мохоо гадаргуутай, нүдний салстыг зүсч гэмтээхээргүй, ил харагдаж байвал:

- чийгтэй, зөөлөн, ариун, самбай материалаар дотроос гадагш чиглэлтэйгээр хөнгөн арчиж авахыг оролдоно. Гэхдээ хэт дарж, үрж арчиж болохгүй.

Хэрвээ гадны биет нь нүдэнд харагдахгүй байвал:

- дээд зовхийг дээш нь зөөлөн татна.
- Нүдний алимыг эргэлдүүлэн хөдөлгөхөд гадны биет аль нэг газар ил гарч ирж болно. Хэрэв ил гараад ирвэл дээрх байдлаар арчиж авна. Өөр ямар нэгэн хатуу зүйлээр ухах, хямсаагаар чимхэх зэрэг оролдлого хийж болохгүй.



Зураг 36. нүдэнд үзлэг хийх

*Дээрх тусламж үр дүнгүй бол:*

5. Нүдийг цэвэр буцалсан усаар урсгаж угаана.

Үүний тулд

- Гэмтсэн хүнээ хэвтүүлэх, эсвэл хагас суулгана.
- Угаах усаа гүц, данх зэрэг нарийн цорготой саванд хийж бэлтгэнэ. Усанд өөр ямар нэгэн зүйл / давс, сод, ариутгагч уусмал, спирт гэх

мэт / хольж болохгүй.

- Аль талын нүдийг угаахаас хамаарч угаах гэж байгаа талын чихний дэлбэнг хумьж чихийг таглаад, толгойг тэр зүг рүү харуулна.
- Усаа эгц дээрээс угаах нүдний дотор өнцөг буюу дээд талаас нь аажим гоожуулж угаана.



*Зураг 37. а: нүдийг угаах*

Дээрх тусламж үр дүнгүй бол:

6. Гэмтсэн нүдэн дээр зөөлөн ариун жийргэвч тавьж бооно.
  1. Эмнэлгийн тусламж дуудах буюу ойролцоох эмнэлэг рүү хүргэнэ.




*Зураг 37. б: нүдийг боох*

Нүдэнд гадны биет зоогдсон тохиолдолд:

DRABC буюу амьсгал, судасны цохилтыг шалгана /2.3-р сэдвийг үз/. Нүдэнд зоогдсон гадны биетийг хөдөлгөөнгүй болгох зорилгоор ариун жийргэвчийг тойруулан

тавьж бэхэлнэ. Энэ нь цус алдах болон бусад хүндрэлээс сэргийлэх ач холбогдолтой.

2. Гадуур нь боолт хийнэ. Эсвэл зурганд үзүүлснээр бэхлэн боож болно.
3. Эмнэлгийн тусламж дуудах буюу ойролцоох эмнэлэг рүү хүргэнэ.



*Зураг 37. а.б.в.г: Нүдэнд гадны биет  
Зоогдоход үзүүлэх тусламж*

Нүд түлэгдсэн тохиолдолд:

1. DRABC буюу амьсгал, судасны цохилтыг шалгана /2.3-р сэдвийг үз/.
2. Нүдийг зөөлөн нээнэ.
3. Нүдийг 20 минутаас доошгүй хүйтэн урсгал усаар угаана. /дээрхийн адил/.
4. Нүдэн дээр ариун жийргэвч тавьж боолт хийнэ.
5. Эмнэлгийн тусламж дуудах буюу ойролцоох эмнэлэг рүү хүргэнэ.

Харин гагнуурын оч, хэт ягаан туяанд түлэгдсэн тохиолдолд:

1. Нүдэн дээр ариун жийргэвч тавьж боолт хийнэ.
2. Эмнэлгийн тусламж дуудах буюу ойролцоох эмнэлэг рүү хүргэнэ.

## **АРВАНГУРАВ. ШОК**

Өмнөх сэдвүүдэд бид зарим гэмтэл хүний зүрх судасны болон амьсгалын тогтолцоонд нөлөөлж улмаар амь насанд аюул учруулдаг тухай өгүүлсэн. Г эхдээ хүнд гэнэтийн болон архаг өвчин, гэмтлээс шалтгаалсан төрөл бүрийн эмгэгийг даван туулах чадвар байдаг боловч тэсвэрлэж үл чадах өвчин болон гэмтлийн улмаас шокод орох улмаар үхэлд хүрдэг.

Энэ сэдэвт шокыг хэрхэн таньж, сэргийлэх, ямар тусламж үзүүлэх талаар судлах болно.

### ***Шок гэж юу вэ?***

Шок гэдэг нь гэнэтийн сэтгэлийн болон биеийн хямрал, гэмтлийн улмаас амьдралын чухал эрхтэн буюу тархи, зүрх, уушгины цусан хангамж алдагдаж тэнд очих хүчилтөрөгч дутагдсаны улмаас биед гарч байгаа өөрчлөлт юм.

### ***Шок хэрхэн үүсдэг вэ?***

Хүний цусан хангамжийг хэвийн байлгахад дараах 3 хүчин зүйл нөлөөлдөг. Үүнд:

1. Зүрхний үйл ажиллагаа хэвийн байх
2. Биеэр хангалттай хүчилтөрөгч агуулсан цус эргэлдэж байх
3. Цусны судасны хана гэмтэж цус алдаагүй, цусны хэмжээ хэвийн байх
- 4.

Хэн нэгэн гэмтэх эсвэл гэнэт өвдөхөд дээрх 3 нөхцөл байдлын аль нэг нь эсвэл бүгд доголддог. Бага зэргийн гэмтэл болон хөнгөн хэлбэрээр өвдөхөд гарах зовиур болон нөлөө нь бага байдаг бөгөөд ийм тохиолдолд эд эс хурдан нөхөн төлждөг. Харин хүндээр өвчлөх болон ноцтой гэмтэх үед цусны эргэлт саатсанаас тархинд очих хүчилтөрөгчийн хэмжээ багасч улмаар шокод ордог.

## Шок нь

1. Цусны хэмжээ багасах,
2. Зүрхний хэмнэл алдагдах болон
3. Мэдрэлийн тогтолцоонд гэмтэл үүссэнээс болдог.
  - Шокын үед илрэх шинж тэмдгүүд
  - арьс чийглэг, хүйтэн, цонхигор
  - амьсгаадсан /1 минутанд 20-иос дээш/.
  - судасны цохилт түргэсч, суларсан.
  - ам их цангасан.
  - дотор муухайрч, бөөлжис цутгасан.
  - ухаан санаа өөрчлөгдөх гэх мэт шинжүүд илэрдэг.



*Зураг 39. Шокын илрэл*

## **АНХНЫ ТУСЛАМЖ**

- шок үүсгэж байгаа шалтгааныг зогсооно.
- амьсгал, судасны цохилтыг шалгаж, тусламж дуудна.
- өөр цус алдалт байгаа эсэхийг шалгаж тогтооно
- тохиромжтой газар хэвтүүлнэ. Энэ нь уг хүнд өвдөлт болон айдас, сэтгэлийн цочролыг бага ч гэсэн таившруулахад тустай
- Биеийн дулааныг хэвийн байлгах Үүний тулд дулаан хөнжил, хувцас зэргээр хучиж дулаацуулах хэрэггэй
- Таившруулж сэтгэл санааг нь засах
- Дахин амьсгал судасны цохилтыг шалгаж.



биеийн байдлыг нягтална.

- Тархины цусан хангамжийг сайжруулах зорилгоор 2 хөлийг дээш өргөнө. Гэхдээ уг хүн нуруу нугас, тархины гэмтэлтэй, мөн хөл болон доод мөчдийн яс хугарсан, эсвэл ямар гэмтэлтэй болохыг мэдэхгүй байгаа тохиолдолд хөлийг өргөж өндөрлөж болохгүй.
- Шокод орж байгаа хүний ам их цангаж, уух юм хүсдэг боловч юм уулгах болон идүүлж болохгүй. Учир нь бөөлжих мөн мэс засалд орох шаардлага гарч болзошгүй.
- Цаг алдалгүй эмнэлгийн тусламж дуудна. Зөвхөн анхны тусламж үзүүлсэнээр шокоос гаргаж чадахгүй тул эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж зайлшгүй шаардлагатай.
- Хэрэв биеийн байдал нь муудвал ухаан алдаж болох бөгөөд энэ тохиолдолд амьсгалахад тохиромжтой байрлал буюу эргүүлэх байрлалд оруулж хэвтүүлэх хэрэгтэй.



*Зураг 40. Шокоос сэргийлэх нь*

### **АНХААР!**

-Цус алдсан, сэтгэлийн хямралд орсон болон өөр ямар нэгэн гэмтэл, хүчтэй өвдөлт зэрэг нь шокод амархан оруулдаг тул ийм хүнд шокын шинж тэмдэг илэрч байгаа эсэхийг байнга ажиглаж байх хэрэгтэй

-Гэмтсэн болон өвдсөн хүнийг шокод орохыг хүлээлгүй цаг алдалгүй түүнээс сэргийлэх нь чухал.

-Шокын шинж тэмдэг илэрч байгаа хүнд маш түргэн анхны тусламж үзүүлж шокыг цааш даамжрахаас сэргийлэх хэрэгтэй.

-Шокын шинж тэмдэг илэрч байгаа хүний амьсгал, судасны цохилт, биеийн байдлыг байнга хянаж байх хэрэгтэй.

## **АРВАНДӨРӨВ. ЗӨӨВӨРЛӨЛТ**

Та бүхэн өмнөх сэдвүүдээс төрөл бүрийн гэмтлийг яаж таних, түүнд хэрхэн тусламж үзүүлэх талаар товч ойлголтуудыг авсан гэдэгт найдаж байна. Дээр өгүүлсэн осол гэмтлүүдтэй учирсан хэн бүхэнд анхны тусламжийг үзүүлсний дараа тулгардаг нэг том асуудал бол гэмтэгсдийг аюул ослын газраас аль болох өөрт болон гэмтсэн хүнд хүндрэл багатайгаар хялбархан холдуулах, ойролцоох эмнэлэгт зөв тээвэрлэн хүргэх явдал байдаг.

Энэ сэдэвт бид Та бүхэнд төрөл бүрийн гэмтэлтэй хүнийг хэрхэн аюулгүй, гэмтлийн дараах хүндрэлгүйгээр зөөвөрлөх тухай өгүүлэх болно.

### ***Гэмтэгсдийг зөөвөрлөх зарчмууд***

Та гэмтсэн хүндээ айж сандралгүй анхны тусламж үзүүлээд түүнийг яаралтай зөөвөрлөх хэрэгтэй. Ихэнх тохиолдолд гэмтсэн хүнийг зөөхдөө гэмтлийг цааш даамжрахаас сэргийлэх зарчмыг баримталдаг. Жишээ нь: хөлний далд хугаралтай хүнийг зөөх явцад хугарсан ясны үзүүрүүд хавиралдаж улмаар арьсыг цоолон ил гарах, зөөлөн эд, мэдрэлийн судал гэмтэх, цус алдах зэргээс сэргийлж хамгийн тохиромжтой, аюулгүй аргыг сонгон яаралтай зөөх хэрэгтэй.

### **Гэмтсэн хүнийг зөөхдөө**

- Тухайн гэмтэл ямар гэмтэл вэ?
- Гэмтсэн хүн хэр зэрэг том биетэй вэ?
- Гэмтсэн хүний биеийн байдал хэр зэрэг байна вэ? Зөөвөрлөх явцад замын ая даах уу? Зэрэг асуултуудад хариулт олох хэрэгтэй.
- Гэмтсэн хүнийг зөөхөд таны биеийн байдал болон хүч тэнхээ хангалттай юу?
- Хаа нэгтээ танд туслах өөр хүн байна уу? Гэсэн асуултуудад хариулт олох хэрэгтэй.

Эдгээр асуултуудад хариулснаар Та гэмтсэн хүнийг хэрхэн ямар аргаар зөөхөө сонгоход тань тус болно.

### **Зөөвөрлөх явцдаа гэмтсэн хүнээ хэрхэн хамгаалах вэ ?**


- Зөөвөрлөх явцад гэмтсэн хүн унах, халтирч ойчих зэргээс болгоомжилж түүнийг түших буюу гараараа сайтар тулж барьж явах хэрэгтэй.
- Гэмтсэн хүнийг авч явахдаа тайван, аажуу, хагас алхах маягаар явах хэрэгтэй.
- Аль болох нэг чигт явах /өөрөөр хэлбэл, ухарч алхахгүй байх/, донсолгоо гаргахаас зайлсхийх хэрэгтэй.
- Гэмтсэн хүний тэнцвэрийг алдагдуулах, таагүй байдал гаргахаас сэргийлэх хэрэгтэй.
- Гэмтсэн хүний, ялангуяа тархи, нуруу нугасны гэмтэлтэй хүний толгой, нурууг гулзайлгахгүй, нэг тэнхлэгт авч явах хэрэгтэй.

Гэмтсэн хүнийг зөөвөрлөхдөө өөрийгөө гэмтээхээс хамгаалах нь зүйтэй.

Төрөл бүрийн гэмтэлтэй хүнийг зөөвөрлөхдөө өөрийгөө гэмтээхээс болгоомжилж аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах нь чухал юм.

Болгоомжгүй өргөх, огцом тонгойх, хэт хүнд зүйл өргөх зэрэг үед хүний нуруу их гэмтдэг. Иймд гэмтсэн хүнийг зөөвөрлөх, өргөхдөө Та дараах зүйлийг санах хэрэгтэй.

- Танд гэмтсэн хүнийг өргөхөд хангалттай хүч байгаа тохиолдолд түүнийг зөөвөрлөх
- Хүнд зүйл өргөх үед өвдөг, ташаа гэмтдэг тул нуруу цэх, толгой эгц, мөр шулуун, хөлдөө мөрний хэмжээний зай аван хагас суугаа байрлалд сууж хүндийн төвийг хуваарилах.



*Зураг 41. Өргөх зөөвөрлөх ажиллагаа*

- Өргөх болон зөөвөрлөх үедээ чанга атгаж барих
- Аль болох аюулгүй замыг сонгон явах

Зөөвөрлөх аргууд:

1. Ганцаараа зөөвөрлөх
  - шагайнаас чирэх
  - гарнаас чирэх
  - хувцаснаас чирэх
  - үүрэх
  - босоогоор нь араас тэврэн гарыг тоонолжлон атгаж чирэх





Зураг 42.а,б,в,г,д:  
Ганцаараа үед зөөвөрлөх  
 аргууд

2. Хоёулаа болон төлөвлөсөн зөөвөрлөлт
- суугаа байрлалаар хоёр талаас нь дамжлах
  - арай илүү хүч чадалтай, том биетэй нь гэмтсэн хүний ард гарч нуруугаар нь тэврэнэ. Нөгөө хүн нь гэмтэгчийн хөлөөс барьж явах
  - нэг хүн түшин алхуулах /суга таяг мэт тулах/
  - хоёр хүн түшин алхуулах
  - 4 гараар суудал хийн суулгах
  - 2 гараар суудал хийн суулгах
  - цагирагаар суудал хийн суулгах
  - түшлэгтэй сандалд суулган зөөх
  - дугуйт сандалд суулган зөөх
  - дамнуургаар зөөх
  - хөнжлөөр зөөх





*Зураг 43. а, б, в, г, д, е, ж, з, и: Хожулаа болон төлөвлөсөн зөөвөрлөлтийн хэлбэрүүд*

### **АНХААР!**

Аль ч хэлбэрийн зөөвөрлөлтийн үед зөөж байгаа гэмтэлтэй хүнийхээ царайг тогтмол ажиглаж, биеийн байдлыг /амьсгал, судасны цохилт, огиулж бөөлжиж байгаа эсэх, гэх мэт/ байнга хянаж явах нь зүйтэй.

## АРВАНТАВ. АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ҮЕД АРИУН ЦЭВРИЙГ САХИХ НЬ

Анхны тусламж үзүүлэхээс өмнө болон үзүүлсний дараа гараа савандаж угаа. Анхны тусламж үзүүлэх үедээ бээлий өмсөх бол өмсөхөөсөө өмнө болон тайлсны дараа мөн гараа угаах хэрэгтэй.

Болж өгвөл биеэс ялгарч байгаа бусад шингэнд хүрэхээс зайлсхийх хэрэгтэй. Цус буюу биеийн бусад шингэнээр норгогдсон зүйлд гараар бүү хүр. Олныг хамарсан гамшиг, осол, дайн байлдааны үед анхны тусламж үзүүлэхдээ дээд зэргийн хянуур байж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч заавал бээлий өмс.

Шархадсан хүнтэй харьцаж байгаа бол шилний хагархай буюу хурц үзүүртэй зүйлээр арьсаа гэмтээхээс болгоомжил.

Хурц үзүүртэй багажийг хэрэглэх, гараар барих, цэвэрлэх, хаях үедээ арьсаа гэмтээхээс сэргийл.

Арьс зүсэгдсэн буюу гэмтсэн тохиолдолд хуурай, цэвэр боолт хий.

Эдгэрэлт удаантай шарх нь онгорхой шарх үлдээж болно. Ийм шархнаас цус алдаж байгаа болон ил шархтай хүмүүстэй шууд харьцахаас зайлсхий.



*Зураг 44. а,б: Ариун цэврийг сахих нь*

*Анхны тусламж үзүүлэхээс өмнө болон үзүүлсний дараа гараа сайтар савандаж угаа*

## **Амнаас аманд зохиомол**

### **амьсгал хийх**

ХДХВ буюу бусад халдвар авахвий гэсэн айдсаас болж зарим тохиолдолд хүний амь насыг авардаг энэхүү чухал үйлдлийг хийхээс татгалздаг. Амнаас аманд зохиомол амьсгал хийх үед ХДХВ-ийн халдвар авсан тохиолдол бүртгэгдээгүй ч, хэрвээ шархтай хүний амнаас цус алдаж байгаа эсвэл анхны тусламж үзүүлэгч өөрөө амандаа ил шархтай тохиолдолд цуснаас шууд зайлсхийх хэрэгтэй.

Шархтай хүний аман дахь цусыг арчиж цэвэрлэн амьсгалын замыг чөлөөлөхийн тулд хэрэв боломжтой бол цэвэр даавуу буюу нусны алчуур хэрэглэ.

Амнаас аманд зохиомол амьсгал хийх үед ердийн нүүрний халхавч буюу маскийг хэрхэн ашиглах аргыг сур. Анхны тусламжийн иж бүрдэлд амны хаалт байх, анхны тусламж үзүүлэгч нь биедээ байнга авч явах ёстой.

**Амны хаалт байхгүй гэсэн шалтгаанаар амнаас аманд зохиомол амьсгал хийхээс татгалзаж болохгүй.**

### ***Цус алдаж буй хүнд тусламж үзүүлэх***

Цус алдах нь хүний амь насанд аюултай тухай өгүүлсэн ба ийм тохиолдолд цусыг тогтоож, анхны тусламж үзүүлэх хэрэгтэй.

- Хэрэв боломжтой бол шархадсан хүнийг өөрөөр нь шархан дээр даруулж цусыг хэрхэн тогтоох талаар зааварчилгаа өг.
- Хэрэв шархадсан хүн ямар нэг шалтгаанаар цус алдалтыг тогтоож чадахгүй бол Та цэвэр, зузаан даавуу болон бусад тохиромжтой материалыг ашиглаж даралттай боолт хийнэ. Хэрвээ даралттай боолтоор цус алдалт тогтоогүй бол ойролцоох том судасны цэг дээр дарах хэрэгтэй.



- Олныг хамарсан гамшиг, осол болон дайн байлдааны үед резин бээлий өмсөх нь зүйтэй.



*Зураг 45. а,б: Цус алдаж буй хүнд тусламж үзүүлэхдээ өөрийгөө хамгаалах*

### ***Шархтай хүний цустай хэрхэн харьцах вэ?***

- Хэрэв таны гар цус болсон бол аль болох хурдан савандаж угаа.
- Хэрэв таны нүд зэрэг биеийн бусад эрхтэн цус болон биеийн шингэнээр бохирлогдсон бол маш их усаар буюу урсгал усаар угаа.
- Хэрэв таны арьс зүсэгдэж ямар нэгэн хэмжээгээр цус гарвал шархыг савантай усаар угааж хуурай, цэвэр боолт тавь.

Халдварт өвчин халдварлах эрсдэлийг бууруулахын тулд анхны тусламж үзүүлэх үедээ ариун цэврийн дэглэмийг баримтлах, урьдчилан сэргийлэх энгийн аргыг хэрэглэх, мэдрэмж сайтай байх нь зүйтэй.

### ***Урссан цусыг цэвэрлэх***

- Урссан цусыг даавуу, алчуур, цаасан алчуур буюу модны үртэс зэрэг шингээх чанартай материалд уусгаж авна. Бохирлогдсон материалыг аюултай хог хаягдал гэж үзэх бөгөөд гялгар уутанд хийх, шатаах, булах зэргээр устгана.
- Цусаар бохирдсон талбайг ариутгалын

уусмалаар угааж ариутгана /гипо-хлоридын давсыг гэрийн нөхцөлд 1:10 харьцаагаар усанд шингэлж, 0,1-0,5 хувийн уусмал бэлтгэн хэрэглэж болно/. Бохирдсон хэсгийг угаахаас өмнө 10-15 минут хүлээх хэрэгтэй.

Бохирдсон хэсгийг цэвэрлэхдээ өргөн хэрэглээний зориулалт бүхий бээлий, ахуйн резинэн бээлий эсвэл ердийн бээлийг давхарлаж өмсөх хэрэгтэй. Хэрэглэж дуусаад гялгар уутанд хийж хаяна.

Хэрэв бээлий байхгүй бол цустай шууд харьцахгүйн тулд өөр бусад тохиромжтой зүйлийг орлуулан хэрэглэнэ.

Хэрэв та ямар нэг халдвар авчихлаа гэж санаа зовж байвал эмчийн зөвөлгөө авч шинжилгээ хийлгэ.



Цус буюу биеэс ялгарсан бусад шингэнийг цэвэрлэсэний дараа гараа сайтар савандаж угаа

*Зураг 46.*

## **5. Цусаар бохирдсон материалуудыг цэвэрлэх нь**

Цусаар бохирдсон хувцас, даавуу болон бусад материалтай маш болгоомжтой харьцах хэрэгтэй.

- Цусаар бохирдсон хувцас, даавуу болон бусад материалтай харьцахдаа өргөн хэрэглээний зориулалт бүхий бээлий, ахуйн резинэн бээлий өмсөх хэрэгтэй ба хэрэглэсний дараа гялгар уутанд хийж хаях, шатаах буюу булах хэрэгтэй.

- Хэрэв бохирдсон даавууг дахин угаах хэрэг гарвал ариутгагч болон халуун усанд/700С градусаас дээш температурт / 25 минут байлгах эсвэл хүйтэн усанд зориулагдсан ариутгагч бүхий усаар угаа.

Цусаар бохирдсон даавуутай харьцахдаа маш болгоомжтой бай.

### **Халдвараас хамгаалах**

Халдвар дамжих эрсдэлийг бууруулахын тулд анхны тусламж үзүүлэгч нар янз бүрийн амны хаалт, боолт хэрэглэдэг бөгөөд энэ нь анхны тусламжийн иж бүрдэлд зайлшгүй байх ёстой. Эдгээр аргыг хэрхэн ашиглах талаар мэдэж байх хэрэгтэй.

- Бээлийг хэрэглэсний дараа хаях.
- Амнаас аманд зохиомол амьсгал хийх үед нүүрний хаалт буюу амны хаалтыг хэрэглэх.
- Бээлийг орлуулан гялгар уут хэрэглэж болох ба бохирдсон зүйлийг хийхэд хэрэглэж болно.
- Биеийн шингэнтэй харьцахгүйн тулд зузаан даавуу буюу бусад материалыг ашиглаж болно.



*Зураг 47. Халдвараас хамгаалах хэрэгслүүд*

Халдвараас сэргийлэх хамгийн сайн хамгаалалт нь гэмтээгүй арьс юм. Гэхдээ арьс гэмтсэн гээд анхны тусламж үзүүлэхээс татгалзаж болохгүй.

### **10.3 Та юу хийж чадах вэ?**

Анхны тусламж үзүүлэхдээ ХДХВ/ДОХ-ын халдвараас сэргийлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон аюулгүй байдлыг дээд зэргээр хангах ёстой. Аюулгүй бэлгийн харьцаанд орох болон дээр дурьдсан өндөр эрсдэл бүхий байдалд орохгүй байх нь ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлийг бууруулна.

## АРВАНЗУРГАА. АНХНЫ ТУСЛАМЖИЙН ИЖ БҮРДЭЛ

Энэ сэдэвт анхны тусламжийн иж бүрдэл, түүнд агуулагдах зүйлс, тэдгээрийг хэрхэн хэрэглэх талаар өгүүлэх болно.

Үүнийг өгүүлэхийн өмнө 1-р сэдэвт тодорхойлсоноор:

Анхны тусламж гэдэг нь аливаа осол гэмтэл, гэнэтийн биеийн хямралын үед эмнэлгийн тусламж иртэл гарын доорхи материал ашиглан өөртөө болон нөхөртөө үзүүлэх тусламжийг хэлдэг гэдгийг эргэн санацгаая. Уг тодорхойлолт ёсоор анхны тусламжийг эм хэрэглэхгүйгээр, наад захын энгийн аргаар, хэрэглэхэд хялбар материалаар үзүүлдэг болох нь харагдаж байна.

МУЗН нь дээрх зарчимд тулгуурлан Олон Улсын Улаан Загалмай ба Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбооноос гаргасан стандартын дагуу анхны тусламжийн иж бүрдлийг бэлтгэдэг.

Хүн бүр гэртээ, машиндаа, ажлын байрандаа анхны тусламжийн иж бүрдэлтэй байх хэрэгтэй бөгөөд энэ нь болзошгүй осол гэмтлийн үед Танд дотны туслагч болно гэдгийг мартаж болохгүй.



Зураг 47. Иж бүрдэл

Аль ч улс оронд өргөн хэрэглэгддэг анхны тусламжийн иж бүрдэлд байдаг зүйлсийн жагсаалтыг дор үзүүлэв.

### АНХНЫ ТУСЛАМЖИЙН ИЖ БҮРДЭЛ

	Жагсаалт	тоо хэмжээ
1	Денатурат спирт 15.0	1 шир
2	Йодын ханд 15.0	1 шир
3	Ариутгасан резин бээлий	1 хос
4	Халуун хэмжигч	1 шир
5	Гар чийдэн /зайтай/	1 шир
6	Хурууны лент	10 ши
7	Балын харандаа	1 шир
8	Тэмдэглэлийн дэвтэр	1 шир
9	Зүү /сүлбээр/	10 шир
10	Мохоо хайч	1 шир
11	Шархны лент /2 x 40/	1 шир
12	Сунадаг боолт/6 см өргөн/	5 шир
13	Сунадаг боолт /8 см өргөн/	5 шир
14	Сунадаг боолт /12 см өргөн/	5 шир
15	Ариун даралттай боолт	5 шир
16	Ариун бинт/7 x14/	1 шир
17	Хөвөн /50 гр/	1 шир
18	Ариун жийргэвч /5x5 см/	5 шир
19	Ариун жийргэвч /10 x 10 см/	5 шир
20	Ариун жийргэвч / 20 x 20 см/	5 шир
21	Гурвалжин алчуур /150x 150x80см/	5 шир
22	Чих цэвэрлэгч /100 шир/	1 уут
23	Амны хаалт	1 шир
24	Шингэн сэлбэх давс/27.9 гр/	1 уут
25	Гарын саван	1 шир
26	Иж бүрдлийн цүнх	1 шир

Иж бүрдэлд байгаа зүйлсийг хэрэглэхийн өмнө ба хэрэглэсний дараа, мөн сар болгон доторх зүйлсийн хугацаа болон ариун чанарт хяналт тавьж, зарим нэг шаардлага хангахгүй зүйлсийг солих болон дутуу байгаа зүйлсийг нөхөж хийж байх хэрэгтэй.

## **АРВАНДОЛОО. ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИАС**

### **Хуулийн зорилт**

Энэхүү хуулийн зорилт нь эрүүл мэндийн даатгалын хэлбэр, хамрах хүрээг тогтоож, эрүүл мэндийн даатгалд даатгуулж шимтгэл төлөх, эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэх, хувиарлах, зарцуулахтай холбогдсон даатгалын болон эрүүл мэндийн байгууллага, төр , иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### **4 -р зүйлээс:**

#### **Эрүүл мэндийн даатгал , түүний хэлбэр**

4.2 Даатгалын тодорхой хэсгийг төр , хуулийн этгээд энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэл , журмын дагуу хариуцна.

4.3 Даатгал нь заавал даатгуулах , сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй байна.

4.4 Иргэн эрүүл мэнддээ учирч болзошгүй хохирлын зардлыг нөхөн төлүүлэх зорилгоор давхар даатгалд хамруулж болно .

4.5 Сайн дурын даатгал болон давхар даатгалын үйл ажиллагааг өмчийн бүх хэлбэрийн даатгалын байгууллага эрхэлж болно.

### **6-р зүйлээс:**

#### **Даатгалд хамрагдах хүрээ**

6.1 Монгол улсын дор дурдсан иргэн эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна.

6.1.1 аж ахуйн нэгж байгууллагын ажилтан

6.1.2 аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн

6.1.3 16 /ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18/ хүртэлх насны хүүхэд

6.1.4 их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлвэрлэлийн төвийн өдрийн ангийн

суралцагч

6.1.5 тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн

6.1.6 хүүхдээ 2 / ихэр бол 3 нас/ хүртэл нь өсгөн

бойжуулж байгаа эх/эцэг

6.1.7 хугацаат цэргийн албан хаагч

6.1.8 малчин

6.1.9 Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэн

6.1.10 ял эдэлж байгаа хоригдол

6.1.11 энэ хуулийн 6.1.1 - 6.1.10 -т зааснаас бусад иргэн заавал даатгуулна

6.2 Гадаадын иргэн , харьяалалгүй хүн эрүүл мэндийн даатгалд сайн дураар

### **7- р зүйлээс:**

**Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ**

7.1 Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дараахь тусламж үйлчилгээ хамаарна.

7.1.1 Дотрын өвчний

7.1.2 Мэдрэлийн тогтолцооны өвчний

7.1.3 нүд , чих арьс халимын , яс, булчин, холбох, нэхдэсийн өвчний

7.1.4 яаралтай бус гэмтэл , мэс заслын өвчний

7.7 Эрүүл мэндийн байгууллага даатгалгүй иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тохиолдолд түүнээс энэ хуулийн 7-р зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан тусламж , үйлчилгээний бодит өртгөөр тооцсон хэмжээгээр төлбөр авна.

### **8-р зүйлээс:**

**Даатгалын шимтгэлийн хувь хэмжээ төлөх журам**

8.2 Даатгуулагч даатгалын шимтгэлээ дараахь журмаар даатгалын санд төлнө.



8.2.1 энэ хуулийн 6.1.1 д заасан даатгуулагчийн төлөх даатгалын шимтгэлийн 50-аас доошгүй хувийг аж ахуйн нэгж , байгууллага , үлдэх хэсгийг даатгуулагч өөрөө

8.2.2 энэ хуулийн 6.1.4 - д заасан даатгуулагчийн даатгалын шимтгэлийг сургуулийн захиргаа хариуцаж, даатгагчтай байгуулсан гэрээний дагуу

8.2.3 энэ хуулийн 6.1.8, 6.1.11 заасан даатгуулагчийн даатгалын шимтгэлийн баг , хорооны Засаг дарга хариуцаж , даатгагчтай байгуулсан гэрээний дагуу

8.2.4 энэ хуулийн 6.1.3 , 6.1.5, 6.1.6, 6.1.9, - д заасан даатгуулагчийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс Даатгалын шимтгэлийг төсвөөс тухайн шатны ерөнхий менежер сард нь багтаан даатгагчид шилжүүлнэ

8.2.5 ял эдэлж байгаа ялтны даатгалын шимтгэлийг хорих байгууллага

8.3 энэ хуулийн 6.1.11, 6.2-т заасан даатгуулагчийн төлөх шимтгэлийн хэмжээг гэрээгээр зохицуулна

8.4 энэ хуулийн 6.1.4, 6.1.8,6.1.11-д заасан даатгуулагч даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол жил бүр , 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.5, 6.1.6, 6.1.7,

6.1.9, 6.1.10-д заасан даатгуулагч сар бүр даатгалын шимтгэл төлнө.

8.5 энэ хуулийн 6.1.4, 6.1.8, 6.1.11-д заасн даатгуулагч дараалсан 12 сараас доошгүй хугацааны даатгалын шимтгэл төлсний дараа даатгалын сангаас эмчилгээ үйлчилгээний төлбөр хийлгэх эрхтэй.

### **13- зүйлээс:**

#### **Даатгалын сангаас гарсан зардлыг нөхөн төлүүлэх**

13.1 Даатгалын сангаас гарсан дараахь зардлыг дор дурдсан этгээдээр нөхөн төлүүлнэ.

13.1.1 гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэндэд нь гэм хор учирсан даатгуулагчийн тусламж үйлчлэгээний зардлын төлбөрийг гэм буруутай этгээдээр

13.1.2 эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас эмчилгээний болон тарилгын дараахь хүндрэл гарсан нь тогтоогдсон тохиолдолд тухайн эрүүл мэндийн байгууллагаар

### **Улсын нийгмийн даатгалын**

**ерөнхий газрын даргын 2003 оны**

**дүгээр тушаалын хавсралт**

Түр оршин суугч иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах журам

- Түр оршин суугч нь одоогийн амьдарч буй нутаг дэвсгэрийн засаг захиргаанд бүртгүүлсэн байна.
- Түр оршин суугч иргэнийг харьяалах баг / хороо/ -ийн засаг даргын тодрохойлолтыг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн харьяа нийгмийн даатгалын байгууллага бүртгэн авч эрүүл мэндийн Даатгалд хамруулна.
- Түр оршин суугч нь эрүүл мэндийн даатгалын гэрчилгээтэй байвал түүнийг нь бүртгэн авагч нийгмийн даатгалын байгууллага нь баталгаажуулан бааз мэдээлэлдээ авна.
- Түр оршин суугч иргэн эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ байхгүй бол шинээр гэрчилгээ олгон бүртгэн авч өөрийн бааз мэдээлэлд оруулна.

**Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын  
даргын 2003 оны 33 дугаар тушаалын хавсралт**

**Эмнэлгийн хуудас олгох зааврыг  
хэрэгжүүлэх журам**

- Даатгуулагч эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд тухайн эмнэлгийн байгууллага зөвхөн хэвтсэн хоногт нь эмнэлгийн хуудас бичиж олгоно. Эмнэлгээс гарсан хугацаанас хойших хугацаанд эмнэлгийн хуудас бичих сунгахыг хориглоно.
- Амбулаториор эмчлүүлсэн даатгуулагчид зөвхөн харьяаллын болон оршин суугаа нутаг дэвсгэрийн эмнэлгийн байгууллага нь эмнэлгийн хуудас олгоно. Гэрээт болон шефр зэрэг харьяаллын бус эмнэлэгт эмчлүүлсэн даатгуулагчид амбулаториор эмнэлгийн хуудас олгохгүй Ор бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүд даатгуулагчдыг амбулатороор эмчилсэн тохиолдолд эмнэлгийн хуудас олгохгүй.
- Эмчлэгч их эмч амбулатороор эмчлүүлсэн даатгуулагчид эмнэлгийн хуудсыг нэг удаад 5 хүртэл хоног, нийтдээ 14 хоногоос илүүгүй хугацаагаар олгоно.
- Өрхийн эмнэлэгт амбулатороор 14 хоногоос илүүгүй хугацаанд эмнэлгийн хуудас олгоно. 14 хоногоос илүү хугацаанд эмнэлгийн хуудас олгох шаардлагатай бол тухайн нутаг дэвсгэрийн амбулаторийн эмч нарын зөвлөлгөөнөөр хэлэцсэн шийдвэрийг үндэслэн эмнэлгийн хуудсыг сунгаж олгож болно.
- Клиникийн нэгдсэн эмнэлэг төрөлжсөн нарийн мэрэгжлийн төвүүд аймаг . дүүргийн нэгдсэн эмнэлэгт хөдөө орон нутгаас харьяаллын дагуу өвчтөн илгээх маягт <sup>0</sup> 13 / А -тай ирж амбулатороор эмчлүүлсэн даатгуулагчдад тухайн эмнэлэг нь эмнэлэг эмнэлгийн хуудас бичиж олгоно.

- Даатгуулагч ээлжийн амралттай хугацаандаа өөрийн харьяаллын эмнэлэгг амбулатороор эмчлүүлбэл эмнэлгийн хуудас олгохгүй. Харин хэвтэн эмчлүүлсэн бол зохих журмаар эмнэлгийн хуудас олгоно.
- Үндсэн байгууллагаас гадуур хэд хэдэн байгууллагад давхар ажил үүрэг гүйцэтгэж байгаа даатгуулагчид эмнэлгийн хуудсыг зөвхөн үндсэн байгууллагаас бичиж олгоно.
- Ердийн өвчний улмаас эмнэлгийн хуудас эмнэлгийн хуудас олгох хугацааны дээд хязгаар нь амбулатороор хуанлийн 30 хоног, амбулатороор болон хэвтэн эмчлүүлсэн хоног нийлээд 91 хоногоос хэтрэхгүй байна.
- Ахуйн ослын улмаас өвчилсөн бол даатгуулагийн эмнэлэгт хэвтсэн хугацааг оролцуулан амбулатороор 91 хоног хүртэл эмнэлгийн хуудас олгоно.
- Тухайн хаунлийн жилд ердийн өвчин , ахуйн ослын улмаас өвчилж 91 хоног эмнэлгийн хуудас авсан даатгуулагч тэтгэмжийн даатгалын санд 3 сараас доошгүй хугацаагаар тасралтгүй шимтгэл төлсөн нөхцөлд дахин тэтгэмж авах эрх үүснэ.
- Хорт хавдар , сүрьеэгээр анх өвчилсөн буюу ердийн өвчнөөр өвчилсөн даатгуулагч хорт хавдар , сүрьеэгээр давхар өвчилсөн тохиолдолд хуанлийн жилд амбулатороор 91 хоног , нийтдээ 182 хоног хэтрэхгүй хугацаанд эмнэлгийн хуудас олгоно.
- Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилсөн даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох хугацааны дээд хязгаар нь амбулатороор хуанлийн 91 хоног, нийтдээ 182 хоногоос хэтрэхгүй.
- Эмнэлгийн байгууллага нь даатгуулагчид \*эмнэлгийн хуудас олгох заавар\*-т заасан хугацаанд бичиж өгөх үүрэгтэй. Тухайлбал. Даатгуулагчийг эмнэлгээс гарсан өдөр нь буюу 5

хоногийн дотор , жирэмсэн эхчүүдэд жирэмсний амралт эхэлснээс хойш болон амаржсаны дараа 10 хоногийн дотор тус тус эмнэлгийн хуудсыг бичиж олгоно.

- Цэргийн албан хаагч хөдөлмөрийн чадвараа түр алдаж өвчилсөн , осолд өртсөн тохиолдолд дээд хязгаар нь ердийн өвчнөөр өвчлөхөд 91 хоногоос, хорт хавдар болон сүрьеэгээр анх өвчлөхөд 182 хоногоос хэтрэхгүйгээр эмнэлгийн хуудсыг бичиж олгоно. Хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн цэргийн албан хаагч эмэгтэй энэ заалтад нэгэн адил хамаарна. Цэргийн албан хаагч хуанлийн жилд удаа дараа өвчилсөн тохиолдолд эмнэлгийн хуудсыг нийтдээ 182 хоногоос илүүгүй хугацаанд олгоно.
- Эмнэлгийн хуудас дараахь тохиолдолд олгохгүй, шаардлагатай бол магадлагаа олгоно. Үүнд:
- Өөрийн эрүүл мэндэд санаатайгаар гэм хор учруулсан , хуурамчаар өвчилсөн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, согтууруулах, мансууруулах зүйл хэрэглэсний улмаас өвчилсөн, осолд орсон эмчилгээнээс санаатайгаар зайлсхийсэн, өвчтөн асарсан, халдавртөвчнийулмаасхөлхорьжтусгаарласан, өөрийн хүсэлтээр үр хөндүүлсэн , өөрийн хүсэлтээр гоо сайхны мэс засал хийлгэсэн

**Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирлын  
2007- 07- сарын 23 -ны өдрийн 83-р тушаалын  
хавсралт**

Эрүүл мэндийн даатгалгүй болон гадаадын харьяат эмчлүүлэгчдээс үйлчилгээний төлбөр авах журам

А. Эрүүл мэндийн даатгалгүй болон өөрийн хүсэлтээр үйлчлүүлэх хүсэлтэй иргэн тус төвийн амбулатороор үйлчлүүлэхэд 2500

төгрөгийн төлбөр, шаардлагатай шинжилгээ , эмчилгээ хийлгэхэд \*Төлбөртэй үзүүлэх тусламж үйлчилгээний тариф, журам батлах \* тухай тушаалын нэгдүгээр хавсралтаар төлбөрөө төлнө. / тусламж үйлчилгээний багцад заасан тарифаар/ Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалаас санхүүжих багцын төлбөрийг төлж хэвтэнэ. Холбогдох шинжилгээний бодит зардлыг хасна.

Б. Гадаадын харьяат иргэн тус төвөөр онош тодруулах шинжилгээний болон хэвтэн эмчлүүлэх төлбөрийг 2 дахин илүү төлбөр төлөхөөр тооцож үйлчлүүлнэ.